



НЭЭЛТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТУРШЛАГАД  
СУУРИЛСАН ГАРЫН АВЛАГА



# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТУРШЛАГАД СУУРИЛСАН ГАРЫН АВЛАГА

Гарын авлагыг боловсруулсан:

Ч.ЛХАГВАСҮРЭН, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй  
эцэг эхийн холбооны Хөвсгөл аймаг дахь салбарын  
зохицуулагч  
Д.БААСАНСҮРЭН, Хөвсгөл аймгийн Боловсрол,  
соёл, урлагийн газрын Насан туршийн боловсролын  
мэргэжилтэн

2020 он

ННА 74.3  
ДАА 371.9  
Л-874



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ БОЛОВСРОЛД  
ТЭГШ ХАМРУУЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ:  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТУРШЛАГАД СУУРИЛСАН ГАРЫН АВЛАГА

Гарын авлагыг боловсруулсан:

Ч.ЛХАГВАСҮРЭН, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны  
Хөвсгөл аймаг дахь салбарын зохицуулагч  
Д.БААСАНСҮРЭН, Хөвсгөл аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын  
Насан туршийн боловсролын мэргэжилтэн

Тус тайлангийн үр дүн, санал зөвлөмж нь судлаачдын дүгнэлт бөгөөд  
Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9678-6-4

© Нээлттэй Нийгэм Форум, 2020

Хаяг: Жамьян гүний гудамж  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240  
Утас: 976-76113207  
Вэб: <http://www.forum.mn>  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

## **ГАРЧИГ**

<b>Удиртгал</b> .....	5
<b>Бүлэг 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах эрх зүйн орчин</b> .....	7
1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрх ба олон улсын гэрээ конвенц .....	7
1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахтай холбоотой эрх зүйн орчин .....	16
1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах нь .....	27
<b>Бүлэг 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалтыг дэмжих Хөвсгөл аймгийн туршлага</b> .....	43
2.1. Сургуульд хамрагдалтыг дэмжих Аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа .....	44
2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд тэгш хамруулах үйл ажиллагааны хэрэгжилт (Хөвсгөл аймгийн зарим жишээ) .....	54
2.3. Сургуулийн Дэмжлэгийн багийн үйл ажиллагаа (Хөвсгөл аймгийн туршлага) .....	65
<b>Бүлэг 3. Төсөлд хамрагдсан сургуулийн туршлага</b> .....	70
<b>Хавсралтууд</b> .....	87

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
АУБ	Анги удирдсан багш
БСУГ	Боловсрол, соёл, урлагийн газар
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГСТ	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө
ДХОУБ	Дэлхийн Зөн Олон Улсын Байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗАН	Заах аргын нэгдэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НБХ	Нийгмийн бодлогын хэлтэс
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
СДБ	Сургуулийн дэмжлэгийн баг
ТББ	Төрийн бус байгууллага
ТХБ	Тусгай хэрэгцээт боловсрол
УИХ	Улсын Их Хурал
ХБ	Хөгжлийн бэрхшээл
ХБХЭЭХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо
ХНХ	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ЭМ	Эрүүл мэнд

## УДИРТГАЛ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (хуучин нэрээр), Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллага хамтран “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах нь” төслийг 2015-2018 онд Хөвсгөл аймагт хэрэгжүүлсэн юм. Уг төслийн үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хэрэгцээт дэмжлэгээр хангах ерөнхий боловсролын сургуульд хамруулан сургах ажлыг хэрхэн зохион байгуулах талаар багагүй туршлага бий болоод байна. Энэхүү туршлагаа Хөвсгөл аймгийнхан бид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах шинэ бодлогыг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа багш, захирал, орон нутгийн удирдлагуудтай хуваалцаж, ажилд нь дэм болох сэдэл зорилгоор уг гарын авлагыг бэлтгэн Танд хүргэж байна.

Энэхүү гарын авлагад тэгш хамруулах боловсролын тогтолцоог дэмжсэн эрх зүйн орчны тайлбар мэдээллийг багтаасны зэрэгцээ шинэ тутам бүрдэж буй эрх зүйн орчныг хэрэгжүүлэхэд орон нутгийн засаг захиргааны манлайлал, аймгийн болон сургуулийн түвшний зохион байгуулалтыг багтаав. Тэрчлэн сургуулийн түвшний үйл ажиллагааг шат, алхам бүрээр нь танилцуулж, боловсруулан ашиглаж байгаа баримт бичиг, маягт, хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын тэмдэглэл зэргийг жишээ болгон орууллаа.

Хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх журмыг зохих ёсоор нь хэрэгжүүлэхэд аймаг, орон нутаг, сургуулийн удирдлага, багш, эцэг эх, асран

хамгаалагчдад мэдлэг мэдээлэл дутагдах явдал гарч байсан ч төслийн дэмжлэгтэйгээр бид өөрийн туршлага бий болгосноо тоймлон хуваалцаж байна. Орон нутаг, гэр бүл, хүүхдийн онцлог, бусад бодит шалтгааны улмаас сургууль, багш нар өөр өөрийн мэргэжлийн шийдвэрийг гаргаж, сонголт хийж ажиллахдаа манай аймгийн туршлагаас шууд хуулж хэрэгжүүлэх, санаа авч сайжруулах суурь болно гэж найдаж байна.

Төслийн хүрээнд бий болсон туршлага, мэдээлэл, маягтуудыг цуглуулахад идэвх санаачилгатай оролцсон Хөвсгөл аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, Мөрөн сумын “Ирээдүй 21 дүгээр зуун” сургууль болон “Титэм” 2 дугаар сургуулийн удирдлага, хамт олонд талархлаа илэрхийлье.

## **БҮЛЭГ 1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

### **1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрх ба олон улсын гэрээ конвенц**

Иргэний сурч боловсрох эрхийг хангах нь төр засгийн үүрэг юм. Төрөөс боловсролын үйлчилгээг суралцагсдын нас, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн сургуулийн өмнөх, ерөнхий (12 жилийн), мэргэжлийн болон дээд, насан туршийн боловсролын тогтолцоо болгон зохион байгуулж, бүх иргэнд хүрч үйлчлэх бодлогыг тунхаглан хэрэгжүүлж байна. Иргэдийг ямар нэг байдлаар ялгахгүй, бүх хүний сурч боловсрох эрхийг хангахын тулд ямар ч түвшин, чиглэлийн боловсролын үйлчилгээ нь хүртээмжтэй, хүрэлцээтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, уян хатан байх<sup>1</sup> ёстой ажээ.

Сурч боловсрох эрхтэй холбоотой энэхүү дөрвөн үзүүлэлт нь төрийн үүрэг бөгөөд хүн бүрт боловсролын үйлчилгээг ялгаварлахгүй хүргэж, бүх нийтийн боловсролын үйлчилгээг зохион байгуулахын тулд төр засаг нь хүртээмжтэй, хүрэлцээтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, уян хатан боловсролын үйлчилгээг бий болгох үүрэгтэй болохыг олон улсын хүний эрхийн гэрээ конвенцуудад тодорхойлсон байдаг.

- **Боловсролын хүртээмж** нь боловсролын түвшнүүдээр ялгаатай байхаас гадна сургалтын чанартай холбоотой үзүүлэлт юм. Заавал эзэмших ёстой суурь боловсролын түвшинд сургуульд сурах боломж, нөхцөлийг хүүхэд бүрт

---

<sup>1</sup> Эх сурвалж: <http://biblioteca.clacso.edu.ar/gsdll/collect/ar/ar-033/index/assoc/D599.dir/11.pdf>



хангах нь төрийн үүрэг мөн хэдий ч заавал эзэмших албагүй дээд болон техник мэргэжлийн сургалтад энэ үзүүлэлт шууд хамаарахгүй. Цаашилбал, суурь боловсрол нь хүүхэд бүрт хүртээмжтэй байх зорилтын хүрээнд үнэ төлбөргүй байна.

- **Хүрэлцээтэй боловсролын үйлчилгээ** нь хүн бүрт сурч боловсрох боломжийг олгосон тогтолцоо бөгөөд үйлчилгээний цар хүрээтэй холбоотой. Тодорхой орон нутагт сургууль байхгүй, багш дутагдалтай гэсэн ямар нэг шалтгаанаар сургуульд явах, сурах боломжгүй байх нөхцөл үүсгэхгүйн тулд төр сургууль байгуулж, санхүүжүүлэхийн зэрэгцээ төрийн бус хэвшлийн сургууль байгуулах боломжийг бүрдүүлэх ёстой.
- **Боловсролын үйлчилгээ хүлээн зөвшөөрөгдсөн** байх нь боловсролын чанарын хэмжүүр юм. Хүрэлцээтэй бөгөөд хүртээмжтэй боловсролын үйлчилгээ сайн чанартай байх ёстой бөгөөд үүнийг боловсролын минимум стандарт, багшид тавигдах мэргэжлийн шаардлага, сургуулийн орчны аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага зэргээр хэмжиж болно. Олон улсын хүний эрхийн гэрээ конвенцын ачаар энэхүү ойлголт улам өргөжин гүнзгийрч байна. Хэлний цөөнхийн хүүхдүүд төрөлх хэлээрээ боловсрол эзэмших, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролд тэгш хамрагдах эрхүүдийг хүндэтгэсэн боловсролын үйлчилгээ нь боловсролын өөрийнх нь хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг зөрчихгүй, үндэсний стандартад нийцсэн, мэргэжлийн багшаар хангагдсан орчинд явагдах шаардлагатай.
- **Боловсролын үйлчилгээ уян хатан** байх нь буюу янз бүрийн орчин нөхцөлд ижил үр дүнд хүрэхүйц боломжийг олгосон мөн чанар нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад мөн шууд хамаатай. Боловсролын үйлчилгээ нь хүүхдийн

хэрэгцээ, нөхцөл байдалд нийцэх ёстой болохоос хүүхэд өөрөө уг үйлчилгээ, нөхцөл байдалд нийцэх гэж өөрчлөгдөх ёсгүй ажээ. Улмаар сургуулийн амьдрал, анги танхимын нөхцөл байдал, хичээл сургалтын зохион байгуулалтад нийцэж чадахгүй гэх шалтгаанаар хүүхдийг сургуульд элсүүлэхгүй байх, завсардуулах нь төрийн үйлчилгээ хүргэж байгаа сургууль хүүхдийн эрхийг зөрчиж байгаа хэрэг төдийгүй боловсролын үйлчилгээг төрөөс үр дүнтэй зохион байгуулж чадахгүй байгаагийн жишээ болно. Цаашилбал боловсрол, сургууль гэсэн ойлголтыг салгаж, боловсролыг зөвхөн сургуульд ирж эзэмших бус, боловсролын үйлчилгээг хүүхдэд хүргэх зарчмын дагуу шорон, эмнэлэг, сүм хийд, гэртээ байгаа, ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдэд хүрч үйлчлэх нь төрийн үүрэг ажээ.

Боловсролд тэгш хамруулах бодлого нь бүх хүүхдэд хүрэлцээтэй бөгөөд хүртээмжтэй боловсролыг хүлээн зөвшөөрөгдсөн түвшинд, шаардлагатай бол уян хатан зохицуулалт хийж хүргэх тухай асуудал юм. Ихэнх хүүхэд сургуульд сурах бөгөөд сургууль нь хүүхэд бүр хамтдаа, ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүйгээр, чанартай албан боловсрол эзэмших, эрүүл, аюулгүй орчин байх ёстой. Өөрөөр хэлбэл хүүхдүүд хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид эрүүл, аюулгүй сургуулийн орчинд мэргэжлийн багшаар заалган, шаардлагад нийцсэн хэрэглэгдэхүүн, төхөөрөмж ашиглах, шаардлагатай бол нэмэлт дэмжлэг авч үндэсний стандартад нийцсэн чанартай боловсрол эзэмших ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар мэргэжлийн бус багшаар, батлагдсан стандартгүй сургалт авч, мэргэшсэн багштай хэр нь сурах бичиггүй, өөрт нь шаардлагатай нэмэлт дэмжлэггүй сурах, сурлагын амжилт гаргаж чадахгүй байгаа нь өөрийнх нь сурах чадваргүй байгаатай холбоотой гэж хандах нь хүүхдийн эрхийн зөрчил, төрийн боловсролын талаар хүлээх үүргийн зөрчил болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тусад нь тусгай анги, тусгай сургуульд мэргэжил эзэмшүүлэх зорилготой хөтөлбөрөөр хязгаарлан сургах нь хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхсан явдал болох эрсдэлтэй. Хэдий тийм боловч тусгай сургууль бүр нь ялгаварлал биш юм. Үндэсний стандартад нийцсэн боловсрол олгож, бусад хүүхдийн адил дараагийн шатны боловсролд дэвшин суралцах боломжийг бий болгосон, нийгмийн харилцааны ур чадвар, туршлага эзэмшүүлэн сургадаг тусгай сургууль нь энгийн ЕБС-иас хамаагүй өндөр зардалтай ч нийгэмд чухал үүрэг гүйцэтгэнэ. Харамсалтай нь, дэлхий нийтийн туршлагаас харахад, өндөр төлбөртэй цөөн хэдэн хувийн тусгай сургуулиас бусад, ялангуяа төрийн мэдлийн тусгай сургуулиуд хүртээмж, хүрэлцээ, хүлээн зөвшөөрөгдсөн болон уян хатан байдлын алийг ч хангаж чаддаггүй гэсэн судалгааны дүн бий.

Боловсролын нийтийн үйлчилгээ, үндсэн тогтолцооны гадна тусдаа орших тусгай сургуулийн тогтолцоо нь боловсролын хөтөлбөрийн шинэчлэл, багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх арга хэмжээ, сурах бичгийн шинэчлэл зэрэг чухал өөрчлөлтөөс хоцрох, улмаар сургалтын чанар муудах, мэргэжлийн багшийн дутагдалд орох, сурах бичиг болон сургалтын хэрэглэгдэхүүний хомсдолд орох зэрэг эрсдэлд байнга өртөж байдаг. Тусгай сургууль нь ердийн ЕБС-ийн гүйцэтгэдэг хүүхдийг нийгэмшүүлэх чиг үүргийг бүрэн гүйцэтгэж чаддаггүй. Тиймээс уг сургуулийг төгсөөд гарсан хүүхдүүдэд нийгмийн харилцааны туршлага, ур чадвар дутагдах, тусгай сургуулийн тусгайлан бэлдсэн орчинд дассан тул дэмжлэггүй шахам нийгэмд ажил хөдөлмөр эрхлэх, бие даан амьдрах бэлтгэлгүй байх эрсдэл үүсдэг. Эдгээр сул талаа арилгасан тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг үе тэнгийн бусад хүүхдээс дутахгүй мэдлэг, нийгмийн харилцааны болон бие даах ур чадвартай болгож төгсгөнө. Тэгш хамруулан сургах бодлого

нь тусгай сургуулийг бус харин тусгай сургуулийн үзүүлж байгаа боловсролын үйлчилгээний хүртээмж, хүрэлцээ, хүлээн зөвшөөрөгдсөн болон уян хатан байдлыг сайжруулахын шаардаж байна.

Харамсалтай нь, тусгай сургууль нь өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тусгаарлан сургах хэлбэр загвараар хэрэгжиж байна. Тусгаарлан сургах гэж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тодорхой нэг, эсвэл хавсарсан согогт төвлөрч зохион байгуулсан тусгай орчинд, хөгжлийн бэрхшээлгүй үе тэнгийн хүүхдүүдээс тусад нь сургаж байгааг хэлнэ. Тусгай бүтэц үүсгэх, эсвэл оношоор нь төрөлжүүлж байгаа нь хөгжлийн бэрхшээлийг сул дорой байдал, эсвэл өвчин гэж үзэн, өвчтэй тул бусадтай адил сурч чадахгүй, улмаар хөгжлийн бэрхшээлд нь нийцсэн боловсрол олгох гэсэн ойлголт, хандлагын үр дагавар юм. Үүнийг хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхалт гэж үзэж болох бөгөөд энэ хандлагын улмаас төрөөс үзүүлж буй боловсролын үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хүрэлцээгүй, хүртээмжгүй болж, хүртэж байгаа тусгай боловсрол нь хүлээн зөвшөөрөгдөхүйц чанартай байж чадахгүй байна.

Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бусдаас ялгаж тусад нь тусгай сургуульд, ингэхдээ тусгай сургуулиудыг дотор нь хөгжлийн бэрхшээлээр бас заагладаг. Энэ нь тусгай сургуульд сурч байгаа хүүхдүүд өргөн мэдлэг олж авах, олон ур чадвараа хөгжүүлж, цаашид нийгэмд амжилттай ажиллаж амьдрах боломжийг хязгаарлах нөхцөлийг төр өөрөө бий болгож буй хэрэг юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах арга зам нь хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүүхдүүд нэг сургуульд, нэгдсэн хөтөлбөрөөр суралцаж, хөгжих ижил тэгш боломжоор хангадаг тэгш хамруулан сургах боловсролын бодлого юм. Гэхдээ буруу ойлголт, хэвшмэл хандлагын улмаас

тэгш хамруулахыг боловсрол, хөдөлмөр эрхлэлт, эдийн засаг, соёлын салбарт хэрэгжүүлэхдээ гажуудуулж хэрэгжүүлэх нь бий. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхдийн хамт сургах ёстой гэж ерөнхий боловсролын сургуульд элсүүлж аваад, “одоо бусад хүүхэдтэй адил өөрөө сур” гэвэл яах вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээг харгалзалгүй бий болгосон орчинд ямар нэгэн дэмжлэггүйгээр бусадтай адил байх шаардлага тавихыг интеграцчилал буюу нэгтгэх, нэгтгэн сургах гэж нэрлэдэг<sup>2</sup>. Энэ загварын нөлөөгөөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай анги байгуулах хэлбэрээр, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг энгийн ангид авсан ч зөвхөн ирцэд нь анхааран, сурлагын амжилтыг орхигдуулах байдлаар хэрэгжүүлэх магадлалтай. Ердийн сургуулийн хичээл сургалтын үйл ажиллагаа (хичээл зохион байгуулалт, заах ба суралцах арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүн, сургуулийн хөгжлийн стратеги гэх мэт)-г өөрчлөхгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг ангид оруулж суулгаснаар тэгш хамруулах боловсрол болохгүй.

Нэгтгэн сургах нь цаашид, яваандаа тэгш хамруулах боловсрол болж хөгжинө гэж ойлгох нь алдаа юм. Учир нь ердийн сургууль одоо байгаагаараа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах таатай орчин мөн гэж ойлгож байгаа хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг элсүүлээд авчих л юм бол тэд өөрсдөө хичээгээд сурч чадах тул хүүхдэд сайн сурахад ямар дэмжлэг шаардлагатай байгаад анхаарахын оронд сайн сурахыг шаардах эрсдэлтэй. Сургууль ч бас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах таатай орчин бий болгох зорилгоор биет орчноо сайжруулахад төвлөрч харин анги, сургуулийн соёл, хандлага, харилцаа, ганцаарчилсан дэмжлэг зэрэг жинхэнэ тэгш хамруулахын үндэс болсон байгууллагын

---

<sup>2</sup> НҮБ-ын Хүүхдийн сан (2012) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрх: Тэгш хамруулах боловсролд хүний эрхэд суурилан хандах нь, A/HRC/25/29 (Женев хот, 2012)

хөгжлийн асуудлуудыг орхигдуулдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангахад нийгэм анхаарахгүй явж ирсний улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо хязгаарлагдах үр дагавар нь өнөөдөр ийнхүү илэрч буй. Хүний эрх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг орхих, тусгаарлах биш харин хэрэгцээнд нь нийцсэн дэмжлэгээр хангаж одоо байгаа үйлчилгээ, нийгмийн амьдралд оролцуулах, яваандаа хэнийг ч ялгаварладаггүй, үлдээдэггүй түгээмэл загварт нийгэм болохыг шаардаж байна. Боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийтийн тээвэр, барилгын салбар нь энэ чиглэлд бусад салбараа манлайлан, бүрэн дүүрэн оролцоог дэмжсэн тохирох хэрэглэгдэхүүн бүхий хүртээмжтэй оролцооны орчин, нөхцөлийг бий болгохоор ажиллаж эхлээд байна. Одоо боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал зэрэг хүний хөгжлийн салбарууд энэ шилжилтийг хийх шаардлагатай байна.

Тэгш хамруулан сургах нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамран сургах тойргийн сургуульд, үе тэнгийн бусад хүүхдийн хамт, тэдний давуу талд түшиглэн, сурахтай холбоотой бусдаас ялгаатай хэрэгцээг нь дээд зэргээр дэмжсэн орчныг бий болгон сургахыг хэлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс гадна шилжин суурьшигч, хэлний цөөнх, ядуу өрхийн, хөдөлмөр эрхэлдэг, удаан хугацаагаар эмчилгээ хийлгэж байгаа, алслагдсан орон нутагт амьдарч байгаа зэрэг боловсролын үйлчилгээний гадна үлдэх эрсдэлтэй хүүхдүүдэд энэ ойлголт хамаатай.

Тэгш хамруулан сургах боловсролыг хэрхэн хэрэгжүүлэх вэ? Энэ нь хүүхдүүд бүгд хамтдаа, амжилттай суралцахад учирч буй саад тотгорыг арилгахад чиглэсэн бодлого шийдвэрийг салбарын удирдлагууд гарган сургуулийн стратегид тусгаж, хэрэгжүүлэх зохион байгуулалтаас эхэлнэ. Мөн хичээл төлөвлөлт, заах арга болон хандлагаа өөрчилж, тохируулгыг төлөвлөн хэрэгжүүлэхэд

багш нарт дэмжлэг үзүүлэх ажлыг сургуулийн захиргаа төлөвлөн хэрэгжүүлэх явдал юм.

Учир нь хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь орчны бусад бэрхшээл, саадтай нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг<sup>3</sup> хэлдэг. Энд тодорхойлсноор, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд амжилттай сурахад өөрийнх нь бие, сэтгэцийн болон хөгжлийн онцлогоос илүүтэй энэ онцлогийг харгалзалгүй бий болгосон орчин, тогтолцоо, үйл явцууд саад болдог бөгөөд энэ нь хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдөх үндэс, хөгжлийн бэрхшээлээр алагчлагдахын шалтгаан болдог. Тиймээс төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах үүргээ биелүүлж, боловсролын үйлчилгээг зохион байгуулж, хүргэж байгаа байдлаа өөрчлөх, багш нарт хөгжлийн бэрхшээлийн талаар эерэг хандлага төлөвшүүлэхэд анхаарах нь чухал болж байна.

Тэгш хамруулан сургах боловсролын талаарх ойлголт, туршлага сүүлийн 30 жилд өргөжин бэхжиж байна. НҮБ-аас 2006 оны 12 дугаар сард баталж, Монгол Улс 2009 онд нэгдэн орсон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэх тухай бие даасан бүлэг багтжээ. 2016 онд УИХ-аар баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд ч мөн сурч боловсрох эрхийг хангахтай холбоотой бие даасан бүлэг бий. Дэлхий нийтийн урт хугацааны хөгжлийн хөтөлбөр болох Тогтвортой хөгжлийн зорилгуудын 4 дүгээр зорилгод тэгш хамруулсан, чанартай, эрх тэгш боломжоор хангасан боловсролын үнэ цэнийг улам баталгаажуулсан юм.

---

<sup>3</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенц, Нэгдүгээр зүйл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын Конвенцод тохирох хэрэглэгдэхүүн<sup>4</sup> хэмээх нэр томъёог оруулснаар боловсролын үйлчилгээг суралцагчийн онцлог, харилцан адилгүй суралцах хэрэгцээнд тохируулах, суралцахад нь тулгарч байгаа саад тотгорыг арилгах арга хандлага бий болсон юм. Энэ нь бидний өнөөдрийг хүртэл ажиллаж бий болгосон, одоо мөрдөж байгаа албан болон албан бус боловсролын бүхий л орчинд тогтсон соёл, бодлого, өдөр тутамд хийж хэвшсэн практикийг өөрчлөхийг шаардах том ажил юм шиг санагдаж болно. Гэтэл энэ нь багш хүүхдийг ажиглан бусдаас ялгаатай хэрэгцээг нь ойлгох, сургууль нь хүүхдийн онцлог хэрэгцээг хангасан нэмэлт дэмжлэгээр хангах төлөвлөлт хийх зэрэг энгийн зүйл юм.

Тэгш хамруулан сургах боловсрол нь хүүхдүүдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, сурах үйл явцад оролцох боломжийг янз бүрийн замаар хангах, бүх хүүхдийн сайн сайхан байдал, амжилтад анхаарах явдал юм. Үүний тулд хөгжлийн бэрхшээл зэрэг онцлог хэрэгцээтэй сурагчдад нэмэлт дэмжлэг хэрэгтэй бол ганцаарчилсан дэмжлэг хангаж өгөх замаар хүн бүрийн суралцах, оролцох боломжийг сургуулийн орчинд бүрдүүлсэн байдлаар үйл ажиллагааг зохион байгуулах нь зүйтэй.

Тэгш хамруулах боловсрол нь нэг талаас үзэл баримтлал, боловсролын философи ч салбарын хууль тогтоомж, бодлого, санхүүжилтийн механизм, удирдлага, үйлчилгээний хүргэлт, хяналт үнэлгээ, статистик бүрдүүлэлт, багш бэлтгэл гээд боловсролын тогтолцооны бүхий л талыг хамруулсан шинэчлэлд хөтлөх стратеги юм. Хүүхэд бүр сурах чадавхтайг хүлээн зөвшөөрөхөөс тэгш хамруулах ажил эхэлнэ.

<sup>4</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг (Монгол Улсын хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, 4.1.3)



Тэгш хамрагдалттай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүүхдүүдийг элсүүлж, бүх хүүхдийг амжилттай сургах өндөр хүлээлт тавьж, хоорондоо ялгаатай чадавх, шаардлага, суралцах хэв маягтай хүүхдүүдийн аль нэгийг нь орхигдуулахгүй уян хатан хичээл зохион байгуулах, заах ба сурах аргыг санал болгоно. Хичээлээ төлөвлөхдөө агуулгын зэрэгцээ суралцагчдын чадавх, сэдэл, тэмүүлэлд анхаардаг болно. Ингэж онцлог хэрэгцээтэй хүүхдэд үзүүлэх ганцаарчилсан дэмжлэгийг сурах орчин, нөхцөлд суулган төлөвлөж, хэрэгжүүлснээр онцлог хэрэгцээтэй сурагчдыг тусгаарлан сургах хэрэгцээ арилж, сургууль бүр тэгш хамруулсан сургууль болох юм. Багш нар өөр хоорондоо ялгаатай хүүхдүүдийг сургуулийн байгаа орчин нөхцөлд зохицон сайн сурахыг шаардахгүй, амжилттай сурахад нь тухайн хүүхдэд ямар дэмжлэг хэрэгтэй байгаад анхаарч ажиллах юм.

Мөн 2016 оноос Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад чиглэсэн эрх зүйн орчин эрчимтэй бүрдэж байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

## **1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахтай холбоотой эрх зүйн орчин**

Манай улс 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг баталж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалахтай холбоотой төрийн үүрэг, иргэд, олон нийтийн оролцоог тодорхойлсон. “Уг хууль нь хөгжлийн бэрхшээлийг хүний эрхэд суурилсан хандлагаар тодорхойлж, хөгжлийн бэрхшээлээр ялгаварлахыг эрс шийдэмгий хориглохын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах, бусадтай хамт боловсролд тэгш хамрагдах зэрэг эрхийг баталгаажуулжээ. Эрхийг тунхаглаад зогсохгүй хүртээмжтэй орчин, бүтээгдэхүүн үйлчилгээний

түгээмэл загвар, хэрэгцээнд нийцсэн тохирох хэрэглэгдэхүүн зэрэг эрхийг хангах механизмыг тодорхой заасан нь уг хуулийн давуу тал юм”<sup>5</sup>.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд сурч боловсрох эрхийг НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын зарчимд нийцүүлэн зохицуулсан нь тэгш хамруулан сургах боловсролыг бодитойгоор хэрэгжүүлэх суурь нөхцөл болж байна.

#### *14 дүгээр зүйл. Сурч боловсрох эрх*

14.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй бөгөөд энэхүү эрхийг нь хангах чиглэлээр төрөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

14.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцүүлэн авьяас билэг, бүтээлч чанар, оюуны болон бие бялдрын чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, орчныг бий болгох;

14.1.2. хувь хүний чадамж болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг хөгжүүлж, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;

14.1.3. бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэх;

14.1.4. хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөр, стандартыг боловсруулах.

<sup>5</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шүүмж, Хуулийн шүүмж цуврал, дугаар 20, Нээлттэй Нийгэм Форум, 2018 он

Мөн уг хуульд хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхах, тохирох хэрэглэгдэхүүн, түгээмэл загвар зэрэг Боловсролын тухай хуульд байхгүй шинэ ойлголт, нэр томъёог оруулсан нь боловсролын эрх зүйн орчин, үйлчилгээнд ашиглаж байгаа ойлголт, хандлагыг яаралтай өөрчлөх хэрэгцээ бий болоод байгааг харуулж байна.

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.2. “хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.3. “тохирох хэрэглэгдэхүүн” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг;

4.1.4. “түгээмэл загвар” гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд дурдсан дээрх нэр томъёо, сурч боловсрох эрхийг хангах зарчмууд нь манай улсад бүр шинэ ойлголт биш бөгөөд боловсролын үйлчилгээг хүргэхтэй холбоотой ялангуяа сүүлийн үеийн зохицуулалтад тодорхой хэмжээгээр тусжээ. Тухайлбал:

Нэр томьёо	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль	Боловсролын салбарын эрх зүй
<i>Хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхах</i>	4.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхгүйг;	<i>Боловсролын тухай хууль</i> 5.1.4. иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана;
		БСШУС-ын сайдын 2018 оны А/243 дугаар тушаалаар баталсан “ЕБС, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм”; 4.2. Ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх; 4.2.1. Хүүхдийг гэр бүлийн байдал, хөгжил, суралцах чадвараар нь ялгаварлахгүй байх, сурлагын амжилтыг бодитой үнэлэх.

<p><i>Тохирох хэрэглэг-дэхүүн</i></p>	<p>4.1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг;          15.1. Бүх шатны сургалтын байгууллага болон мэргэжил олгох төв нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид амьдрах ухаан, мэргэжлийн ур чадварыг үр дүнтэй эзэмшүүлэх бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;          15.1.1. тухайн суралцагчийн онцлогт тохирсон хамгийн зохистой арга хэлбэрээр боловсрол олгох;          15.1.2. хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг онцлог хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;</p>	<p>ХНХ-ын сайд, БСШУС-ын сайд, ЭМ-ийн сайдын 2018 оны хамтарсан А/304, А/699, А/460 тушаал “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх заавар”;          3.6.1. Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдэд бусад хүүхдүүдийн адилаар сурч боловсрон өдөр тутмын амьдралд оролцох бололцоог олгохдоо сургуульд хэт ачаалал дарамт үүсгэхгүйгээр тохируулга, өөрчлөлтийг хийж сурах орчин нөхцөлийг бүрдүүлж доорх алхмын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд хүлээн авахад чиглэсэн бэлтгэлийг ханган, тохируулга хийх шаардлагатай.          БСШУС-ын Сайдын 2019 оны А/292 дугаар тушаал “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах” журам</p>
---------------------------------------	--	--

	<p>15.1.4. сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн заах арга зүй, арга барил эзэмшсэн багш, сурган хүмүүжүүлэгч явуулдаг байх; 15.1.5. хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах идэвх, санаачилгыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, тэдний онцлог хэрэгцээнд нийцүүлэн брайль үсэг, дохионы хэл болон харилцааны бусад арга хэлбэрийг хэрэглэх, орон зай, чиг баримжааны чадвар олгох, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх.</p>	<p>- Сургууль нь хүүхдийн ялгаатай байдал, хэрэгцээг хүндэтгэсэн уян хатан сургалтын бодлого, хөтөлбөр, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөгжлийн хоцрогдлыг илрүүлэх, хөгжлийг дэмжих багшлахуй, мэдээллийн технологийг ашиглах, сургалтын орчин, тохирох хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, хүүхдэд учирч болох эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх, хүртээмжтэй, чанартай, адил тэгш боломжийг олгоно.</p>
<p><i>Түгээмэл загвар</i></p>	<p>4.1.4. нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг;</p>	<p>ХНХ-ын сайд, БСШУС-ын сайд, ЭМ-ийн сайдын 2018 оны хамтарсан А/304, А/699, А/460 тушаалаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх заавар” 3.6.1. Тэгш хамруулан сургах ба тохирох хэрэглэгдэхүүн 3.6.2.2 “Нийтлэг загвар”-ыг хичээлд ашиглах “Нийтлэг загвар” гэж хүн бүр ашиглах боломжтой хэв маягаар төлөвлөсөн загварыг [ойлгоно].</p>

Манай улс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах бодлогын орчныг 2018 оноос хойш хурдацтай бүрдүүлж байна. Үүнээс өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн асуудлыг Бага, дунд боловсролын тухай хуулийн “тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, бие даалгах үйлчилгээ үзүүлэх, бага, суурь, бүрэн дунд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллага мөн. Ерөнхий боловсролын бусад сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй” хэмээн зохицуулж иржээ.

Боловсрол нь ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулахыг чухалчилж “бүх хүүхдэд үйлчлэх зорилготой эрүүл мэнд, боловсрол зэрэг үйлчилгээний байгаа дэд бүтцэд тулгуурлан ажиллаж, тусдаа буюу зэрэгцээ тогтолцоо бий болгохоос аль болох зайлсхийх шаардлагатай”<sup>6</sup>. Тэгш хамруулан сургаж байгаа хүүхдэд ээлтэй сургууль, хүүхдийн эрхийг дээдлэгч сургууль, нээлттэй сургууль нь сургуульд элсэх, сурлагын амжилт гаргах, анги дэвшихэд хүүхдүүдэд тулгарч болох саад тотгорыг арилгахыг зорьдог.

Саад тотгорыг арилгах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ганцаарчилсан дэмжлэг үзүүлэх асуудлыг хууль тогтоомж, бодлогоор хэрхэн зохицуулсан байдаг вэ? Энэ асуултад хариу болгон тэгш хамруулан сургах боловсролын 3 зангилаа асуудал болох сургуульд элсэх, сургууль завсардалтаас сэргийлэх, анги дэвших болон сургууль төгсөх шалгалтыг боловсролын эрх зүйд хэрхэн зохицуулсныг харцгаая.

---

<sup>6</sup> ННФ (2012). Бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээл. Асуудал дэвшүүлсэн тайлан, ДЭМБ-ын бүтээлийн орчуулга

### *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд элсэлт*

Хүүхдийг сургуульд элсэхтэй холбоотойгоор баг/хорооны Засаг дарга, хамран сургах тойргийн сургуулийн захирал, эцэг эх тодорхой үүрэг хүлээдэг бөгөөд үүнд:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28.1.5-д зааснаар баг, хорооны Засаг дарга нь хүн амын боловсролын түвшнийг судлах, сургуулийн өмнөх насны хүүхдийг бүртгэж тухайн жилд нь сургуульд оруулах, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулах арга хэмжээ авч ажиллах ёстой.
- Бага, дунд боловсролын тухай хуулийн 20.2.8-д зааснаар ЕБС-д 6 настай хүүхдийг элсүүлэх бөгөөд сургуулийн захирал нь хамран сургах тойргийн хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, тэдэнд суурь боловсрол заавал эзэмшүүлэх... үүрэгтэй. Мөн БСШУС-ын Сайдын 2019 оны А/292 тоот тушаалаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах” журамд **“Сургууль (захирал)** нь жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тухайн сум, хорооны “Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-тэй хамтарч ажиллан, жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөндөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах асуудлыг заавал тусгаж, хэрэгжүүлж ажиллана” гэж заажээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14.4-т эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмшүүлэх сургалтад хамруулах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлэхэд нь боловсролын байгууллагын нийгмийн ажилтан холбогдох мэдээллээр хангах үүрэгтэй гэж заажээ.



Эдгээр албан тушаалтан, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд элсүүлэх асуудлаар хэрхэн хамтран ажиллахыг ХНХ, БСШУС, ЭМ-ийн Сайд нарын хамтарсан 2018 оны А/304, А/699, А/460 тушаалаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх заавар”, БСШУС-ын Сайдын 2019 оны А/292 тоот тушаалаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”-аар маш тодорхой зохицуулж, хэрэгжүүлэх алхмуудыг нарийвчлан зураглан гаргаж өгсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд элсүүлэхэд чухал үүргийг Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл гүйцэтгэнэ. Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийг сум, хороог түшиглэн байгуулж, 6 настай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурахтай холбоотой хэрэгцээг тодруулах, ингэхдээ хомсдолын зарчмаар (чадахгүй зүйлсийг нь олж тогтоох) биш давуу талд нь түшиглэх зарчмыг баримтлахаар заажээ. Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байх бөгөөд уг бүрэлдэхүүн нь олон салбарын мэдлэг, оролцоог дайчлах салбар дамнасан зохион байгуулалттай юм. Үүнд:

- Боловсролын хэлтэс/Боловсрол, соёл, урлагийн газрын асуудал хариуцсан мэргэжилтэн;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын боловсролын мэргэжилтэн;
- Хүүхдийн суралцах сургуулийн захирал;
- Сургалтын менежер;
- Нийгмийн ажилтан;
- Сургуулийн эмч;
- Хүүхдийн асран хамгаалагч зэрэг байна.

Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл нь хүүхэд, түүний ар гэрийн амьдралыг судалж, суралцахад нь шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүн, шийдвэрлэх боломжтой хугацаа, хэн хариуцан хэрэгжүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэнэ. Зөвлөл нь харьяа нутаг дэвсгэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээлэл (эмнэлгийн онош, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэр)-ийг авч, хүүхдийн суралцах сургуулийн захиргаанд хичээл эхлэхээс 6-аас доошгүй сарын өмнө албан ёсоор дамжуулан, сургууль, эцэг эх/асран хамгаалагчийн уулзалтыг зохион байгуулна. Өөрөөр хэлбэл, Зөвлөл нь тухайн орон нутагт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, мэдээллийг нэгтгэх, сургуульд хамруулах ажлыг төлөвлөн, зохион байгуулах үүрэгтэй. Ингэхдээ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэрийн маягт, тухайн хүүхдийн хувийн хэрэг, өмнө нь хамрагдаж байсан боловсролын байгууллагын шилжүүлэх бичиг зэргийг хүүхдийн эцэг эх/асран хамгаалагчаас авч, хурал дээрээ танилцуулна.

Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлаар хүүхдийн бодит байдал, хэрэгцээг судлахын зэрэгцээ сургууль, сурахтай холбоотой хүүхэд, түүний эцэг эх/асран хамгаалагчийн хүсэлтийг сонсоно. Мөн хурлаар хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлсон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэр, эсвэл эмнэлгийн байгууллагын онош, согог зүйч, хэл засалч, хөдөлгөөн засалч, сэтгэл зүйчийн дүгнэлтийг үндэслэн хичээл болон хичээлээс гадуур шаардлагатай дэмжлэгүүд (эрүүл мэнд, нийгмийн халамж, сэргээн засалт г.м.)-ийн талаар тодруулж ярилцана. Хүүхэд сургуульд элсэх нас хэтэрсэн буюу 6-аас дээш настай бол хэддүгээр ангид оруулах асуудлаар зөвлөлдөнө.

Эдгээрт үндэслэн Зөвлөл нь дүгнэлтээ гарган, албан ёсны маягтад

зөвлөмж хэлбэрээр бичиж тэмдэглэнэ. Энэхүү тэмдэглэл нь тухайн хүүхдэд сургуулиас хангаж өгөх тохирох хэрэглэгдэхүүний зөвлөмж болох тул сургуульд хэт ачаалал, дарамт үүсгэхгүйгээр хэрэгжүүлэх боломжтой арга замыг эрэлхийлэх шаардлагатай.

Энэхүү тэмдэглэлийн маягт нь хамран сургах тойргийн сургуулийн Дэмжлэгийн багт хүргэгдэнэ. Ингээд сургуулийн зүгээс тохирох хэрэглэгдэхүүнийг хариуцан хэрэгжүүлэх үүрэг бий болж байна.

### *Сургууль завсардахаас сэргийлэх арга хэмжээ*

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуульд элсэн орсон ч завсардах нь их байдаг бөгөөд ихэнх нь 1 ба 2 дугаар ангидаа, зарим нь 5 дугаар ангийн төгсгөлд завсардаж байгааг олон улсын судлаачид тогтоосон. Уг асуудалд БСШУС-ын Сайд анхаарлаа хандуулж, тодорхой зохицуулсан байдаг.

БСШУС-ын Сайдын 2018 оны А/155 тоот тушаалаар батлагдсан “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах заавар”, ХНХ, БСШУС, ЭМ-ийн Сайдын нарын хамтарсан 2018 оны А/304, А/699, А/460 тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх заавар”, БСШУС-ын Сайдын 2019 оны А/292 тоот тушаал батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”, БСШУС-ын Сайдын 2019 оны А/528 тоот тушаалаар батлагдсан “ЕБС-ийн сургалтын үйл ажиллагаанд баримтлах чиглэл”, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаас гаргасан ердийн цэцэрлэг, ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ганцаарчлан ажиллаж байгаа үндсэн болон туслах багшид тэдний албан тушаалын (үндсэн) цалингийн 10 хувьтай тэнцэх нэмэгдэл хөлс тооцож олгох шийдвэр зэрэг баримт бичгүүдэд завсардалтыг сэргийлэх зорилт, арга хэмжээ багтжээ.

### 1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах нь

Дээр дурдсан эрх зүйн орчныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүүхдийг сургууль завсардалтаас сэргийлэхийн тулд сургууль дараах алхмуудыг хийнэ. Эдгээр нь:

1. Сургуулийн Дэмжлэгийн баг байгуулах;
2. Тэгш хамруулан сургах орчин бүрдүүлэх;
3. Хүүхдийн хэрэгцээнд нь нийцсэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, үр дүнд хяналт үнэлгээ хийх;
4. Бусад сурагч, тэдний эцэг эхийн ойлголт, оролцоог дээшлүүлэх буюу хандлага өөрчлөх үйл ажиллагаа хэрэгжүүлэх зэрэг болно.

Дээрх 4 чиглэлийн үйл ажиллагааг нарийвчлан авч үзье.

#### *Сургууль дээр Дэмжлэгийн баг байгуулах*

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд элсэж байгаа сургуулийн захирал тушаал гаргаж, Дэмжлэгийн багаа байгуулна.

**Чиг үүрэг.** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийн дагуу сургууль нь хүүхдийг бүртгэж авна. Сургуулийн зүгээс хичээлийн байрны орчин нөхцөл тохиромжгүй, багшийн бэлтгэл хангагдаагүй, төсөв хангалтгүй зэрэг шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг элсүүлж авахаас татгалзаж болохгүй бөгөөд энэ нь өнөөгийн эрх зүйн орчноор хүний эрхийн зөрчил, хууль зөрчсөн үйлдэлд тооцогдоно. Дэмжлэгийн баг нь тэгш хамран сургах боловсролын хэрэгжилтийг хангах мэргэжлийн баг учир тохируулгат сургалтын орчныг бий болгож, сургууль, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн эргэх холбоог сайжруулахад анхаарч ажиллана.

Дэмжлэгийн багийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:

- тухайн хүүхдийн хөгжих, сурахад шаардлагатай сургалтын хөтөлбөр (Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, ерөнхий болон засан сайжруулах хичээлийн агуулгыг тодорхойлох), хүүхдийн хэрэгцээнд суурилсан ялгаатай хичээл, судлагдахууныг сонгон судлах асуудлыг Сургуулийн зөвлөлөөр шийдүүлэх;
- сурах бичиг, гарын авлага, аудио, видео, брайл хэрэглэгдэхүүнийг бэлтгэх;
- багш, эцэг эх, асран хамгаалагчид сургалт зохион байгуулах, багшийн арга зүйг тасралтгүй хөгжүүлэх;
- эцэг эх, асран хамгаалагчийн эерэг хандлага, нөлөөллийг дэмжих;
- хүүхдийн аюулгүй, саадгүй, хүндрэл бэрхшээлгүй сурч, хөгжих тохируулгат хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэхэд оршино.

Дэмжлэгийн баг нь шаардлагатай хүүхдэд Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахаас гадна хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн тохирох хэрэглэгдэхүүний хангамж хэрэглээнд мөн хяналт тавина.

**Бүтэц бүрэлдэхүүн.** Дэмжлэгийн баг нь сургууль дундын бүтэцтэй байж болох бөгөөд бүрэлдэхүүн нь тухайн сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, орон нутгийн онцлог, мэргэжилтний нөөц, сургалтын орчин, хүүхдийн болон эцэг эх, асран хамгаалагчийн санал, хүсэлтэд тулгуурласан байна. Шаардлагатай тохиолдолд Дэмжлэгийн багт тухайн орон нутгийн эмнэлэг, нийгмийн хамгааллын мэргэжилтэн цагаар ажиллаж болно. Хэрвээ орон нутагт тухайн мэргэжилтэн байхгүй/ дутагдалтайн улмаас хүүхэд боловсролд хамрагдахгүй байх нөхцөл бий болохоор бол орон нутгийн засаг захиргааны байгууллага

нь хүсэлт гаргаж, өөр газраас мэргэжилтэн урьж, зөвлөн туслах үйлчилгээ авч ажиллана.

**Үйл ажиллагаа.** Тус баг нь улиралд нэг удаа хуралдаж, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг засаж сайжруулахын зэрэгцээ цаашдын чиглэлийг хэлэлцэж, үр дүнг Боловсролын хэлтэс/Боловсрол, соёл, урлагийн газарт тайлагнана.

БСШУС-ын Сайдын 2018 оны А/155 тоот тушаалаар батлагдсан Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ахуй амьдрал, суралцах үйлд тулгарч буй саад тотгорыг хэрхэн тодорхойлж, яаж арилгахаар төлөвлөж байгааг баримтжуулан, явц ахицыг тэмдэглэх баримт бичиг юм. Энэхүү баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, тохиромжтой тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг төлөвлөх, сургуулийн болон гэрийн орчинд тухайн хүүхэдтэй ажиллах сургалтын агуулга, багшийн болон мэргэжилтний арга зүй, дэмжлэгийн тогтолцоо, сурагчийн хөгжлийн ахиц зэрэгтэй холбоотой дүгнэлт, мэдээлэл багтана.

Гэхдээ уг Төлөвлөгөөг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрт биш, харин ердийн сургалтын хөтөлбөрөөр суралцахгүй, явцын үнэлгээгээр үнэлэгдэх сурагчийн хувьд боловсруулах зохицуулалттай. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг Дэмжлэгийн баг, хүүхдийн эцэг эх/асран хамгаалагч зэрэг хүмүүс хамтран боловсруулах бөгөөд үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулна. Хүүхдийг мэддэг, түүний эрх ашгийг дээд зэргээр хамгаалах талууд, хүүхэд өөрөө оролцсоноор хүүхдийн хэрэгцээ, хүсэл сонирхлыг оновчтой тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлэх хамтын ажиллагааны суурь тавигдах юм.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ гэхээр сурагчтай ганцаарчилж ажиллах, жижиг бүлэг болгож салгах,

эсвэл хичээлийн бус цагаар зориулалтын анги, кабинетад хичээллэнэ гэсэн үг биш юм. Харин анги танхимдаа, бусад хүүхдийн хамтаар өдөр тутмын ердийн хичээл дээр тухайн хүүхдэд дэмжлэг үзүүлэх, сургалтын хувилбарт арга зүй, тодорхой хэрэглэгдэхүүн ашиглан хэвийн хичээл, сургалтад оролцуулахыг хэлнэ.

Ер нь тэгш хамруулан сургах нь багшийн ур чадварын хөгжилд маш их тустайгаас гадна хөгжлийн бэрхшээлгүй олон хүүхдэд ашиг тусаа өгдөг байна. Хүүхдийн байдлаас шалтгаалан салбар комиссын дүгнэлтийг үндэслэн нөхөн сэргээх нэмэлт сургалт, үйлчилгээ (хэл засал, хөдөлгөөн засал, өөртөө үйлчлэх, нийгэм ахуйн баримжааны сургалт, брайл үсэг, орон зайн баримжааны сургалт, дохионы хэл) зохион байгуулах нь үндсэн сургалтыг орлохгүй.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө нь тусгаарласан орчноос ердийн сургалтын байгууллага руу, мөн боловсролын шат түвшин хооронд шилжих асуудлыг тусгасан байна. Тэгш хамран сургах тухай журамд тусгай сургуулиас ердийн сургуульд шилжин суралцах сонголтыг хүндэтгэн, шийдвэрлэх тухай заасан байдаг.

### *Тэгш хамруулан сургах орчин*

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол бол зөвхөн Дэмжлэгийн багийн ажил биш бөгөөд сургууль бүхэлдээ хүүхдүүдийн ялгаатай байдал, хэрэгцээг хүндэтгэн, уян хатан бодлого, хөтөлбөр, эерэг хандлага, таатай орчинд анхаарч, хүртээмжтэй, чанартай, адил тэгш боломжийг олгосон соёл бий болгох үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, бүх хүнийг ижил тэгш хүлээн зөвшөөрсөн байгууллага, хамт олон болохын тулд багш, ажилтнуудын болон сурагчдын дундах, багш сурагчдын хоорондын ялгаатай байдлыг хүндэтгэсэн, эерэг, ээлтэй, харилцан хүндэтгэлтэй хандлага, харилцаа, соёл хамгаас чухал. Сурагчид

хичээлийн явцад алдаж будилах, эсвэл сайн ойлгохгүй байх нь сурах үйл явцад гардаг хэвийн зүйл гэдгийг ойлгон загнаж үгүйсгэхгүй, хүүхэд айж эмээх зүйлгүй тайван, идэвх, сонирхолтой суралцах анги танхимын орчин мөн чухал.

Сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн сурах, нийгэмших, манлайлах гээд бүхий л талын оролцоог хангахад туслах орчин бөгөөд шаардлагатай бол нэмэлт болон туслах хэрэгсэл, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах үүрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бусад хүүхдийн адил хэмжээнд сурах, сургуулийн өдөр тутмын амьдралд оролцох бололцоог олгохдоо сургуульд хэт ачаалал, дарамт үүсгэхгүй тохируулга, өөрчлөлтийг хийж, сурах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд доорх алхмууд тус болно. Үүнд:

- **Сургуулийн биет буюу материаллаг орчны хүртээмжийн үнэлгээ хийж, илэрсэн саадыг арилгах.** Шинээр барилга барих, хуучин барилга байгууламжийг засварлахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүн суралцан сургуулийн өдөр тутмын амьдралд оролцоход нь хүндрэл бэрхшээл учруулахуйц биет саад тотгорыг арилгах, шат дараалан багасгах зорилт тавьж өөрчлөх нь зүйтэй. Мөн сургалтын материаллаг хэрэгсэл, хэрэглэгдэхүүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ашиглах боломжтой байхаар сайжруулах хэрэгтэй. Сурах орчин нь зөвхөн сургуулийн байшин барилгаар хязгаарлагдахгүй, нийт сурагчийн ашиглах сургууль орчмын талбай, сургуульд ирэх, гэртээ харих зам, тоглоомын талбай, ногоон орчин зэрэг багтана. Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүүхэд бүрт, насанд хүрэгчдэд сургуулийн биет орчин хүртээмжтэй байх юм бол хөгжлийн бэрхшээлтэй нэг нь бусдаас тусламж авахгүйгээр бие даан орж гарах, дотор нь зорчих, өөрийн хүссэнээр анги танхим, спорт болон хурлын заал, номын сан, гуанз, ариун цэврийн өрөөг ашиглах, сургуулийн



орчинд бусад хүний ашигладаг дэд бүтцийг тэгш ашиглах боломжтой болно.

- **Нийтлэг загвар/түгээмэл загварыг ашиглах.** Байшин барилга, зам талбай, орц гарц гээд биет орчны дизайны шийдлийг бүх хүнд хүртээмжтэй байх боломжийг харгалзан сонгох, үүний зэрэгцээ сургалтын үйл явцыг төлөвлөн хэрэгжүүлэхдээ бүх хүүхдэд ижил хүртээмжтэй байх, бүгдийг оролцуулсан арга зүйг сонгох, боломжтой бол сурахуйн түгээмэл загварыг ашиглана. Сурахуйн нийтлэг/түгээмэл загвар нь суралцагч бүрийн суралцах онцлог хэв маягийг хүлээн зөвшөөрч, сургалтын уян хатан аргагүйг боловсруулах, ангид бүх хүүхдийн оролцоог хангасан орчин бий болгох, бүх суралцагч амжилттай сурч чадна гэсэн өндөр хүлээлттэй байхын зэрэгцээ хувилбарт аргууд ашиглан хүлээлтээ биелүүлэх боломжийг багшид олгодог. Боловсролын стандарт нь нэг боловч түүнийг хангах, сургах аргагүй нь суралцагч бүрийн хэрэгцээг харгалзан уян хатан төлөвлөгдсөнөөр хэрэгжих боломж бүрдэх бөгөөд үүнийг дагаад үнэлгээ уян хатан, олон хэлбэртэй байх болно.

Эдгээр нь тодорхой хэмжээний санхүүжилт шаардлагатайгаас гадна мөн ур чадвараа нэмэгдүүлэх, мэргэшихийг багшаас шаардана. Сургууль нь багш нараа суралцах боломжоор хангах, тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх, орчны хүртээмжийг сайжруулах асуудлыг жил бүрийн төсөвтөө тусган өөрийн дотоод нөөцөөр шийдэх боломжтой. Ийм боломж байхгүй бол хуулиар боловсролын удирдах байгууллага, эрүүл мэнд, халамжийн салбар, орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллах боломжийг олгосон байгаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулж байгаа сургууль нь хүүхдийн онцлогоос хамааран тусгай хэрэгцээт боловсролын багш, эсвэл туслах багш ажиллуулах асуудлыг Сургуулийн

зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэх нь зүйтэй. Мөн орон тоо, цалин хөлсний нэмэгдлийг орон нутгийн засаг захиргаанд хандан дэмжлэг авч шийдвэрлүүлэх боломжтой.

БСШУС-ын Сайдын 2019 оны А/528 тушаалаар баталсан “ЕБС-ын сургалтын үйл ажиллагаанд баримтлах чиглэл”-д “суралцах бэрхшээлтэй суралцагчид нэмэлт тусламж үзүүлэх, тэдний онцлогт тохирсон үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлж, ахиц өөрчлөлтийг үнэлэх, суралцагч бага боловсролоос суурь боловсролд шилжин суралцахад үүсэх хүндрэл бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх”-ийг сургуульд үүрэг болгосон байна. Улмаар хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн сурлагын амжилт, анги дэвшихэд дэмжлэг үзүүлэх нь зөвхөн анги даасан багшийн хариуцах асуудал биш харин сургуулийн захиргааны хариуцах ажил бөгөөд анги даасан багш нь тодорхой асуудал, бэрхшээл, гарч байгаа ахиц дэвшлийг сургуулийн удирдлага, бусад багш, ажилтан, эцэг эхэд мэдээлж байх хэрэгтэй.

Тэгш хамруулан сургах боловсролын хэрэгжилт нь зөвхөн үүрэг хуваарилалтаар хязгаарлагдаагүй бөгөөд сургууль, багшийн ажлыг үнэлэх нэг шалгуур болоод байна. БСШУС-ын Сайдын 2019 оны А/803 тушаалаар баталсан “ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагааг үнэлэх журам”-д сургуулийн захирал, багшийн ажлын үнэлгээний шалгуурт дараах хэдэн үзүүлэлт багтжээ. Үүнд:

- 1.2.4. сургуулийн захирал, удирдлагын багаас хүүхдийн сурах болон хөгжих үйл явцыг дэмжих, тэгш хамран сургах соёл төлөвшүүлэх талаар хийж буй ажил, үр дүн;
- 3.1.1. сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг суралцагчийн суурь мэдлэг чадвар, ялгаатай байдал, хэрэгцээ сонирхлыг харгалзан адил тэгш оролцоог хангасан байхаар төлөвлөж, үр дүнтэй зохион байгуулдаг байдал;

- 3.2.6. хичээлийн явцад хүүхдийн онцлогийг харгалзан хөгжлийн ахицыг дэмжсэн сургалтын идэвхтэй арга хэрэглэж, хамтын оролцоог хангаж буй байдал;
- 3.2.7. суралцах бэрхшээл, сурлагын хоцрогдолтой, эсхүл чадварлаг суралцагчийн хэрэгцээг тооцсон ялгаатай арга, техник хэрэглэх байдал;
- 3.3.4. суралцах бэрхшээлтэй суралцагчид нэмэлт тусламж үзүүлэх, тэдний онцлогт тохирсон үйл ажиллагаа төлөвлөн, хэрэгжүүлснээр гарсан ахиц, өөрчлөлт;
- 4.1.6. сургуульд шинээр элссэн болон бага ангиас дунд ангид дэвшин суралцаж буй суралцагчид сургуулийн орчин, сургалтын үйл ажиллагаанд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх зохион байгуулалттай арга хэмжээ явагддаг байдал;
- 4.1.9. сургуулийн орчинд суралцагчид бие биеэ ялгаварлан гадуурхах, дээрэлхэх, дарамтлах зэрэг үйлдэл гаргахын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн зэрэг болно.

Тэгш хамруулах сургах боловсролын хэрэгжилтийг төсөв санхүүгээр дэмжсэн зохицуулалтууд хэрэгжиж байна. БСШУС-ын Сайдын 2018 оны А/292 тоот тушаалаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журам”-д сургууль нь дараа жилийн төсвийн төлөвлөгөөндөө Засгийн газраас баталсан журмын дагуу суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсах зардлын нормативыг 3 дахин нэмэгдүүлж тооцох, уг заалтыг хэрэгжүүлэхдээ тухайн хичээлийн жилд суралцаж байгаа болон шинээр элсэх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог Боловсролын удирдлага, мэдээллийн санд оруулж, баталгаажуулсан байхаар журамлажээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшийн урамшууллыг сургуулийн Дотоод журам, багштай байгуулсан Хөдөлмөрийн гэрээнд тусгасан байх ёстой бөгөөд тухайн

хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах шаардлага гарвал Хөдөлмөрийн гэрээнд нэмэлт оруулж болохыг багш нар анхаарна уу. 2020 оны БСШУС-ын Сайдын А/296 тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид нэмэгдэл хөлс олгох заавар” батлан гарсны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшийн нэмэгдлийг 2021 оны 1 дүгээр сараас олгож эхлэх юм.

### *Тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэлт, үр дүнгийн хяналт*

**Нийтлэг/түгээмэл загвар** ашиглах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангахын аль аль нь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг хангах зорилготой, хоорондоо ялгаатай ойлголт билээ. Нийтлэг/түгээмэл загвар нь ялгаатай хэрэгцээтэй хүмүүс нэмэлт тохируулга, зохицуулалт хийхгүйгээр ашиглах боломжийг тооцоолж бүтээсэн дизайн бүхий орчин, бараа, бүтээгдэхүүн байх бөгөөд үүнийг аажмаар, дэвшилттэйгээр хэрэгжүүлж болно. Жишээлбэл, урсдаг шат нь настай, залуу, овор ихтэй юм барьсан, хүүхэд тэвэрсэн, жирэмсэн, тулах эрхтний болон хөдөлгөөний бэрхшээлтэй, ядарсан хүмүүс бүгд дээш гарахад ашиглаж болох нийтлэг/түгээмэл загвар юм.

Эргэдэг таглаатай савыг онгойлгоход биеийн хүч, хоёр гарын ажиллагаа шаардлагатай тул дарж хий оруулаад амархан онгойлгож болох савны нийтлэг/түгээмэл загвар нь илүү олон хүнд нийцтэй дизайнд багтана. Орчны хувьд тэргэнцэртэй, овор ихтэй юм авч яваа хүнд саадгүй, хэн ч гэсэн чөлөөтэй зорчиж, бусдын тусламж гуйхгүйгээр ашиглаж болох дотоод зохион байгуулалт нь мөн л нийтлэг/түгээмэл загвар юм. Налуу зам бол зөвхөн тэргэнцрийн зам биш, шатаар авирч гарах боломжгүй ямар ч хүнд байшинд нэвтэрч ороход учрах саадыг арилгасан нийтлэг/түгээмэл загвар юм.

Иймээс нийтлэг буюу түгээмэл загвар нь бүх хүн ашиглахаар бодож хийсэн зүйл бөгөөд сургалтад мөн зөвхөн унших юмуу, зөвхөн сонсох арга зүй ашиглахгүй, сонсох, унших аргыг нэгэн зэрэг ашиглан мэдээлэл өгөх аргыг багш төлөвлөн, сургалтын материалаа бэлдэх замаар хэрэгжүүлж болно.

**Тохирох хэрэглэгдэхүүн** нь тухайн нэг хувь хүнд зориулагдсан арга хэмжээ бөгөөд тохирох хэрэглэгдэхүүнээр хангах асуудлыг нэн даруй шийдвэрлэх ёстой. Ижил төрөл хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид дотроо харилцан адилгүй хэрэгцээтэй байдаг тул тэдний бүрэн дүүрэн оролцоог хангахын тулд үйл ажиллагаа, орчин, сургалтын хэрэглэгдэхүүн болон арга зүйн хувьд өөр өөр тохируулга хийх шаардлагатай болно. Тиймээс тохируулга/тохирох хэрэглэгдэхүүн/боломжит тохируулга нь тухайн нэг хүүхдэд зориулсан дэмжлэг, нэмэлт үйлчилгээ юм.

Тохирох хэрэглэгдэхүүний тухайд “нэг хэвэнд цутгах” хандлагаар ажиллаж болохгүй. Сургуулийн орчны тохирох хэрэглэгдэхүүнд анги танхимын байршлыг өөрчлөх, анги дотроо өөр өөр хэлбэрээр харилцах боломжийг зохион байгуулах, сургалтын материалыг том үсгээр, эсвэл хурц өнгөөр хэвлэх, агуулгыг зураг, тэмдэглэгээгээр илэрхийлэх, мэдээллийн агуулгын хүрээг өөрчлөхгүй үг хэллэг, өгүүлбэрийн найруулгыг хялбарчлан бэлтгэх, тэмдэглэл хөтлөгч эсвэл хэлмэрчээр хангах, туслах технологи ашиглах зэрэг багтана.

Материаллаг бус тохиргоонд сурагчийн даалгавар гүйцэтгэх цагийг сунгах, гаднын дуу чимээг бууруулсан орчин бий болгох, үнэлгээний хувилбарт арга ашиглах, сургалтын хөтөлбөрийн зарим бүрэлдэхүүн хэсгийг орлуулах, цахимаар харилцах зэрэг багтана. Энэ талаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих цогц заавар”-т дэлгэрэнгүй өгүүлснийг үзээрэй.

Багш, Дэмжлэгийн баг, сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй сурагч, шаардлагатай тохиолдолд тэдний эцэг эх, асран хамгаалагчийг байлцуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар Комиссын дүгнэлтийг харгалзан хүүхдийн онцлог, сонголтод нийцүүлэн тохиргоог хийнэ. Тохирох хэрэглэгдэхүүнийг сонгохдоо хүүхдийн согогийн талаарх эмнэлгийн оношоос илүүтэй сурах болон нийгэмших явцад тулгарч буй саадыг арилгахад баримжаалан, бусад хүүхэдтэй ижил түвшинд оролцох боломжоор хангах зарчимд нийцүүлэн сонголт хийхийг зөвлөж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай холбогдох эрх зүйд тохирох хэрэглэгдэхүүнээр хангахаас татгалзах, энэ чиглэлд арга хэмжээ авахгүй байх нь хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхсанд тооцогдоно.

БСШУС-ын Сайдын 2020 оны А/249 тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл” нь ЕБС-ийн тусгай танхимд түшиглэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурч боловсроход нь тулгарч буй саад, тотгорыг арилгах, бууруулахад чиглэсэн сургалт, хүмүүжил, засан сайжруулах, хөгжүүлэх болон зөвлөн туслах үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах тухай зөвлөмжийг агуулж байгаа бөгөөд эдгээр нь үндсэн сургалтыг орлохгүй, харин түүнд нэмэлт болон дэмжлэг болгож зохион байгуулах ёстойг анхаарна уу. Тусгай танхим, төвөөр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нэмэлт хичээл, давтлага, сэргээн засах болон хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа нь боловсролын үйлчилгээ хүргэж байгаа хэрэг биш, тэр дундаа тэгш хамруулан сурах боловсролын үйлчилгээ хэрэгжүүлж байгаа хэрэг биш юм.

*Бусад сурагч, тэдний эцэг эхийн хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж, тэгш хамруулахтай холбоотой оролцоог дээшлүүлэх (хандлага өөрчлөх үйл ажиллагаа)*

Боловсролын үйлчилгээг хэрэгжүүлэгч ЕБС нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах төрийн бодлогыг хэрэгжүүлэхдээ зөвхөн багш, ажилтан төдийгүй бусад сурагч, тэдний эцэг эх, гэр бүлд идэвхтэй нөлөөлөн, тэднийг гэгээрүүлэн сургах үүрэг хүлээж байна. Төрөөс ийм бодлого хэрэгжүүлж байгааг тайлбарлан таниулах нь уг бодлогын хэрэгжилтийг хангахад учрах саадыг арилгаж, олон нийтийн дэмжлэгийг олж авах зорилт мөн багтаж байгаа болно. Үүнийг баталгаажуулан БСШУС-ын Сайдын 2019 оны А/803 тушаалаар батлагдсан “ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагааг үнэлэх журам”-д ЕБС-ийн үйл ажиллагааг дүгнэхдээ хүүхдийн сурах, хөгжих үйл явцыг дэмжих, тэгш хамран сургах соёл төлөвшүүлэх, дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтыг урьдчилан сэргийлэх чиглэлд сургуулийн захирал, удирдлагаас хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг харгалзахаар заасан.

Сургууль нь хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхахыг дотоод дүрэм журмаараа хориглож, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг аливаа ялгаварлан гадуурхалтаас хамгаалах зорилготой арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэхдээ бусад хүүхэд, тэдний эцэг эхээс үүдэлтэй харилцаа, хандлагын саад тотгорыг арилгаж идэвхтэй ажиллах хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлийг өвчин, сул дорой байдал, байнгын нэмэлт анхаарал шаардсан бие, оюуны хомсдол гэж буруу ташаа ойлгодог зарим эцэг эх хүүхэдтэй нь нэг ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах боломжгүй гэж үзэх нь бий. Тэд сургууль, багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулиас хасах шаардлага тавихаас гадна энэ үзэл хандлагаа хүүхдэдээ “өвлүүлэх” эрсдэлтэй тул сургууль нь эцэг эхчүүдэд эрх тэгш оролцооны ойлголт хандлагыг төлөвшүүлэх, хүний

эрхийн боловсрол олгох хэрэгтэй болж байна. Үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж болно.

Хүүхэд, тэдний эрх ашигтай холбогдох аливаа арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэхдээ Хүүхдийн эрхийн конвенцод заасны дагуу хүүхдүүдийг өөрсдийг нь оролцуулах хэрэгтэй. Үүний нэгэн адилаар, охидтой холбогдох асуудлаар охидыг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өөрсдөө шийдвэрт оролцох эрхтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах нь сургууль, анги танхимын орчин, нэмж бүрдүүлэх дэмжлэг, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өөрөө оролцож, хүсэл сонирхлоо илэрхийлэх боломжтой байхаас эхэлнэ. Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцох, секц дугуйланд хамрагдах, номын сангаар үйлчлүүлэх, тоглож наадахтай холбоотой асуудлаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ямар саад учирч байгааг, эдгээрийг хэрхэн яаж арилгах талаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс асуугаарай.

БСШУС-ын Сайдын 2018 оны А/425 тоот тушаалаар батлагдсан “ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-аар тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийг тухайн төлөвлөгөө, хөтөлбөрт нийцсэн шалгуураар үнэлэх тухай заажээ. Шалгуурыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран гаргахаар заасны дагуу буюу Боловсролын Хүрээлэн, Боловсролын Үнэлгээний Төв боловсруулах юм.

Хөгжлийн бэрхшээлийн онцлогоос шалтгаалан Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөтэй суралцаж буй сурагчийн хөгжлийн ахиц, сурлагын амжилтыг явцын үнэлгээгээр үнэлэхээр журамд



заажээ. Явцын үнэлгээгээр сурлагын амжилтыг нь дүгнэж байгаа сурагчийн анги дэвших, сургууль төгсөх асуудлыг явцын үнэлгээнд үндэслэн Шалгалтын комисс шийднэ гэж энэхүү журмын 4.6-д заажээ.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч шалгалт өгөх тохиолдолд тэдний онцлог хэрэгцээнд тохирсон шалгалтын орчин бүрдүүлэхээр заасан байгаа нь тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж бусад сурагчтай хамт шалгалтад оруулах зохицуулалт юм. Үүнийг БСШУС-ын Сайдын 2019 оны А/292 тоот тушаалаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журам”-аар баталгаажуулсан. Мөн БСШУС-ын Сайдын 2019 оны А/528 тоот тушаалаар баталсан “ЕБС-ийн сургалтын үйл ажиллагаанд баримтлах чиглэл”-ийн 2.3.5-д “Суралцах бэрхшээлтэй суралцагчид нэмэлт тусламж үзүүлэх, тэдний онцлогт тохирсон үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлж, ахиц өөрчлөлтийг үнэлнэ” гэж заасан нь тохирох хэрэглэгдэхүүнээр хангах сургуулийн үүргийг сануулж байгаа хэрэг юм.

Тэгш хамруулан сургах боловсролыг хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурлагын амжилт, ахицыг үнэлэхэд тулгардаг саад тотгорыг илрүүлэн, шийдвэрлэх шаардлага тулгарна. Суралцагчийн сурлагын амжилтыг стандартчилсан шалгалтын оноогоор хэмждэг үнэлгээний уламжлалт аргачлал нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад сул тал бий болгодог. Мөн сурагчдын авсан онооны нийлбэрээр тодорхой багш, сургуулийн чансааг үнэлдэг явдал нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг шалгалтад оруулахгүй завсардуулахад хүргэх нь бий. Тиймээс тэгш хамруулан сургах боловсролын бодлогыг хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж ижил тэгш өрсөлдөх боломжийг олгох, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөтэй суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй сурагчийг сурлагын ахицаар үнэлэх тухай олон жил яригдсан

асуудал ийнхүү журамлагдаж, боловсролын үнэлгээний тогтолцоо албан ёсоор шинэчлэгдэж байна.

Гагцхүү нэг асуудлыг анхаарах шаардлага тулгарч байна. Тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдан шалгалт өгч байгааг бусад хүүхдээс өөрөөр үнэлэх гэж ойлгож болохгүй. Шалгалтын материалыг хүртээмжтэй болгох, хариултаа тэмдэглэх хангалттай цаг гаргаж өгөх, уншиж өгөх, эсвэл хариулсныг нь тэмдэглэх хүн гаргаж өгөх зэргээр шалгалтын явцад тохируулга хийж байгаа нь шалгалтыг уян хатнаар зохион байгуулж байгаа хэрэг төдий бөгөөд энэ нь боловсролын үндэсний стандартын дагуу боловсруулагдсан үнэлгээний аргачлал, онооны системд нөлөөлөхгүй. Цэцэрлэг, ЕБС-ийн үйл ажиллагааг үнэлэхдээ “сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг суралцагчийн суурь мэдлэг чадвар, ялгаатай байдал, хэрэгцээ сонирхлыг харгалзан адил тэгш оролцоог хангасан байхаар төлөвлөж, үр дүнтэй зохион байгуулдаг байдал, хичээлийн явцад хүүхдийн онцлогийг харгалзсан, хөгжлийн ахицыг дэмжсэн сургалтын идэвхтэй арга хэрэглэж, хамтын оролцоог хангаж буй байдал, суралцах бэрхшээл, сурлагын хоцрогдолтой эсхүл чадварлаг суралцагчийн хэрэгцээг тооцсон ялгаатай арга, техник хэрэглэх байдал, суралцах бэрхшээлтэй суралцагчид нэмэлт тусламж үзүүлэх, тэдний онцлогт тохирсон үйл ажиллагаа төлөвлөн, хэрэгжүүлснээр гарсан ахиц, өөрчлөлт” гэсэн шалгуур үзүүлэлт ашиглахаар заажээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуульд элсэн орох, бага ангиас дунд анги руу, мөн сургууль хооронд шилжин суралцах явдлыг саад бэрхшээлгүй, чирэгдэлгүй зохион байгуулах асуудлыг БСШУС-ын Сайдын 2019 оны А/528 тушаалаар баталсан “ЕБС-ын сургалтын үйл ажиллагаанд баримтлах чиглэл”, БСШУС-ын Сайдын 2019 оны А/803 тушаалаар баталсан “ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагааг үнэлэх журам” зэрэгт тодорхой зохицуулсан нь тэгш хамруулан сургах боловсролын бас нэгэн чухал алхам

юм. “Суралцагч бага боловсролоос суурь боловсролд шилжин суралцахад үүсэх хүндрэл бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх” чиглэл баримтлан, “сургуульд шинээр элссэн болон бага ангиас дунд ангид дэвшин суралцаж буй суралцагчид сургуулийн орчин, сургалтын үйл ажиллагаанд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх зохион байгуулалттай арга хэмжээ” хэрэгжүүлж байгаа эсэхээр нь сургуулийг дүгнэх юм.

## **БҮЛЭГ 2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТЫГ ДЭМЖИХ ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТУРШЛАГА**

2016 онд ЖАЙКА Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага санаачлан БСШУСЯ, ХНХЯ-тай хамтран “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах нь” нэртэй уг төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Хөвсгөл аймаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих цогц үйлчилгээний загварыг турших зорилгоор төслийн үйл ажиллагааг 2016-2019 онд хэрэгжүүлсний үр дүнд аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулахад бусад салбар, засаг захиргааны нэгж хамтран ажиллах тогтолцоо, туршлага бүрдэн, тогтвортой ажиллаж байна.

Төслөөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлэх 18 ба 36 сартай хүүхдийн иж бүрэн үзлэг, бага насны хүүхэдтэй өрхүүдийг дэмжих Эх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр, хүүхдийг сургуульд бэлтгэх Портеж хөтөлбөр, туршилтын Сургуулийн дэмжлэгийн баг болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, орон нутгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах төлөвлөгөөт арга хэмжээ хэрэгжсэн юм. Уг төслийн туршлага, үр дүнд түшиглэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах аймгийн дэмжлэгийн тогтолцоог Хөвсгөл аймагт хэрхэн хэрэгжүүлж байгааг танилцуулж байна.

## **2.1. Сургуульд хамрагдалтыг дэмжих Аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа**

ХНХ, БСШУС, ЭМ-ийн Сайдын хамтарсан А/304, А/699, А/460 дугаар тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”-ын 3.7-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Засаг дарга 2019 оны А/247 дугаар захирамж гаргаж, Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүн, ажиллах журам, үйл ажиллагааны чиглэлийг баталсан.

### *Зөвлөлийн бүрэлдэхүүн*

Зөвлөлийг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга удирдаж гишүүдэд аймаг, сум, багийн засаг захиргаа, аймгийн боловсролын болон хамран сургах тойргийн сургууль, цэцэрлэгийн удирдлага, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын төлөөлөл, нийт 11 хүн багтаж байна. Зөвлөлийн Нарийн бичгийн даргаар аймгийн БСУГ-ын мэргэжилтэн ажиллуулахаар томилсон юм.

Зөвлөлийн бүрэлдэхүүнд олон салбарын төлөөллийг багтаасан нь салбар хоорондын уялдаа холбоог хангаж хүүхэд, гэр бүл төвтэй арга зүйгээр ажиллах боломж олгов. Боловсролын салбараас сургуулийн өмнөх, бага болон насан туршийн боловсролын төлөөлөл, мөн боловсролын төсөв, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн багтаж байна. Засаг захиргааны төлөөлөл нь аймаг, сум, багийн түвшин, салбарын төлөөлөл нь нийгмийн бодлого, боловсрол, эрүүл мэнд, эрх мэдэл талаасаа бодлого, шийдвэр гаргагч, бодлогын дунд түвшний менежер, мөн үйлчилгээний байгууллагын төлөөлөгчид энэ Зөвлөлийг бүрдүүлж байгаа юм.

Хөвсгөл аймгийн Засаг даргын  
2019 оны А/247 тоот захирамжаас

**Нэг. Дэмжлэгийн Зөвлөлийн бүрэлдэхүүн**

Дарга: Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

1. Боловсрол, соёл урлагийн газрын хэлтсийн дарга
2. Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
3. БСУГ-ын Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн
4. БСУГ-ын Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн
5. БСУГ-ын төсөв, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн
6. Хүүхдийн харьяалагдах сумын Засаг дарга
7. Хүүхдийн оршин суугаа багийн Засаг дарга
8. Хамран сургах тойргийн сургуулийн захирал
9. Хамран сургах тойргийн цэцэрлэгийн эрхлэгч, багш
10. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын Нарийн бичгийн дарга
11. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын эмч Нарийн бичгийн дарга: БСУГ-ын Насан туршийн боловсролын мэргэжилтэн

***Зөвлөлийн ажиллах журам***

Аймгийн Засаг даргын захирамжид Сургуульд хамрагдалтыг дэмжих Зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамрагдах боломж нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг зохицуулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч

боловсрох эрхийг хангах, хамгаалах орон нутгийн механизм болохыг онцолжээ. Зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг 6 насанд нь сургуульд элсүүлэх, сурах явцад нь гарч болох саад тотгорыг арилгах зорилготой дэмжлэгийн арга хэмжээг тодорхойлж, шийдвэр гарган ажиллахаар зохицуулжээ.

*Хөвсгөл аймгийн Засаг даргын  
2019 оны А/247 тоот захирамжаас*

**Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд  
хамрагдалтыг дэмжих зөвлөлийн ажиллах журам**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиуд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурч боловсрох эрхийн тухай олон улсын гэрээ конвенцод нийцүүлэн энэхүү журмыг боловсруулав.

- а. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангах, боловсролд тэгш, хүртээмжтэй хамрагдах боломж нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулан ажиллана.
- б. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалтыг дэмжих аймгийн зөвлөл нь энэхүү журмыг мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллана.

**Хоёр. Зорилго**

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг насанд нь сургуульд элсүүлж, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлд нь тохирсон дэмжлэг үзүүлэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх

### **Гурав. Зөвлөлийн хурлын зохион байгуулалт**

- 1.1. Хурлаар 5,6 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулахад шаардлагатай дэмжлэгийг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 1.2. Зөвлөл жилд 2 удаа хуралдана.
- 1.3. Зөвлөлийн өргөтгөсөн хурлыг жил бүрийн 5 дугаар сард тогтмол зохион байгуулна.
- 1.4. Хурлаас гарах шийдвэрийг Зөвлөлийн дарга гаргах ба Зөвлөлийн гишүүдийн олонхын саналыг харгалзан үзнэ.
- 1.5. Хуралд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь эцэг, эх, асран хамгаалагчийн хэн нэгэнтэй хамт биеэр ирж оролцоно.

Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлаар тухайн хүүхдийн бодит байдлыг судалж, асран хамгаалагчийн хүсэлтийг харгалзан сургуульд хамруулах асуудлыг шийдвэрлэдэг. Хүүхдийн бодит байдлыг судлах зорилгоор тухайн хүүхдийн талаар цугларсан баримт материалтай танилцан хэлэлцдэг бөгөөд үүнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссоос тухайн хүүхэдтэй холбоотой гаргасан шийдвэрийг тэмдэглэсэн маягт (*Хавсралт-2*), хүүхдийн хувийн хэрэг, цэцэрлэгт хамрагдаж байсан бол одоогийн түвшнийг тогтоосон дүгнэлтийн хуудас зэрэг материалыг багтаан судлахаар заажээ. Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд аймгийн БСУГ, аймгийн ГБХЗХГ, сум болон багийн Засаг дарга, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, эцэг эх, асран хамгаалагч, мөн ТББ-ууд тодорхой эрх үүрэгтэй оролцохоор аймгийн Засаг даргын баталсан журамд тусгагджээ.



Хөвсгөл аймгийн Засаг даргын  
2019 оны А/247 тоот захирамжаас

**Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд  
хамрагдалтыг дэмжих зөвлөлийн ажиллах журам  
(үргэлжлэл)**

**Гурав. Зөвлөлийн хурлын зохион байгуулалт (үргэлжлэл)**

- 1.6. Хурлаас гарсан шийдвэрийг тусгасан хүүхдийн талаарх товч мэдээлэл бүхий шийдвэрийн маягтыг хүүхдэд өгч, холбогдох байгууллагад илгээнэ.
- 1.7. Хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх үүргийг доор дурдсан байгууллагууд хүлээнэ.

**Дөрөв. Холбогдох байгууллагуудын эрх, үүрэг**

- 4.1. Боловсрол, соёл, урлагийн газрын эрх, үүрэг  
(Бүлэг 3-аас БСУГ-аас Зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг хэрхэн төлөвлөсөн жишээг үзнэ үү).
- 4.2. Сумын засаг даргын эрх, үүрэг
- 4.3. Сургууль, цэцэрлэгийн захирал эрхлэгчийн эрх, үүрэг
- 4.4. Хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын эрх, үүрэг
- 4.5. Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын эрх, үүрэг
- 4.6. Эцэг эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг
- 4.7. Төрийн бус байгууллагын эрх, үүрэг

Тайлбар: Хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой байгууллагуудын эрх үүргийг Хавсралт 3-аас харна уу.

### *Зөвлөлийн үйл ажиллагаа*

Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл жилд 2 удаа хуралдан 6 настай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд элсүүлэх, хүлээн авахад шаардлагатай бэлтгэлийг судалж, хэлэлцэхийн зэрэгцээ хүүхдийн ар гэрийн амьдрал, сургуулийн тохируулгат орчин, эрүүл мэнд, нийгмийн хамгаалалтай холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Мөн өмнө гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хянах зорилгоор хуралдахаар журамд заажээ.

Зөвлөлийн хурлаас гарах шийдвэрийг гишүүдийн саналыг харгалзан хурлын дарга гаргана.

*Хөвсгөл аймгийн Засаг даргын  
2019 оны А/247 тоот захирамжаас*

***Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд  
хамрагдалтыг дэмжих зөвлөлийн ажиллах журам  
(үргэлжлэл)***

**Тав. Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын үйл ажиллагаа**

- 5.1. Сургуульд хамрагдалтыг дэмжих хурлын зорилго
- Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй болон сургуульд хамрагдахад хүндрэлтэй байгаа хүүхдэд үзүүлэх дэмжлэг, авах арга хэмжээг хэлэлцэх;
  - Зорилтот хүүхдүүдийн сургуульд хамрагдаж буй нөхцөл байдлыг тодруулж, хяналт хийх, нэмэлт дэмжлэг үзүүлэх шаардлагатай эсэхийг хэлэлцэх.

**Журмын 5.2.** Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын хуваарийг тодорхой заасан байна. Уг хуваарийн дагуу Зөвлөлийн эхний хурал нь ирэх хичээлийн жилийн элсэлтийн бүртгэл

явагдах үеэр буюу 5 дугаар сард болох ба энэ хурлаар элсэхгүй үлдэх эрсдэлтэй хүүхдүүдэд анхаарал хандуулж, сургуулийн Дэмжлэгийн багуудтай хамтран хүүхдэд шаардлагатай дэмжлэгийг хангах асуудалд төвлөрч ажиллана. Зөвлөлийн дараагийн хурал 10 дугаар сард болох бөгөөд уг хурлаар элсэлтийн нөхцөл байдалтай танилцаад, өмнөх 5 дугаар сарын хурлаар хэлэлцсэн тодорхой хүүхдүүдийн элсэлт, дэмжлэгийн асуудлаар ажиллана. Мөн Зөвлөл нь 9 дүгээр сард хуралдаж, элсэлтийн явц, нөхцөл байдлын талаар мэдээлэл авна.

---

### Сургуульд хамрагдалтыг дэмжих хурал

5 сар Бэлтгэл бүлэгт бүртгүүлээгүй, эсвэл сургуулийн зүгээс бэлтгэл бүлгийн хичээлийн агуулга хүндэднэ гэж үзсэн хүүхдүүдийг тус хуралд хамруулан, шаардлагатай дэмжлэгийг хэлэлцэж, шийдвэр гаргана. Хурлаас гарсан шийдвэрийг харьяа сургуульд илгээнэ.

---

5 сар Зөвлөлийн хурлын шийдвэрт үндэслэн сургуулийн Дэмжлэгийн баг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульдаа хүлээж авч, сурах нөхцөл боломжоор хангах бэлтгэлийг хэлэлцсэн талаар аймгийн Дэмжлэгийн зөвлөлийн даргад хариу мэдээлэл ирүүлнэ.

---

9 сар Элсэлтийн байдалтай танилцаж, зөвлөгөө өгнө.

---

10 сар Зөвлөлийн 5 дугаар сарын хурлаар танилцуулсан хүүхдүүд сургуульд хамрагдаж буй байдалд хяналт тавих, нэмэлт дэмжлэг шаардлагатай байгаа эсэх асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргана.

---

**Журмын 5.3** дугаарт Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлыг хэрхэн зохион байгуулах тухай зааж өгчээ. Хурлыг

аймгийн БСУГ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс хариуцан зохион байгуулах үүрэгтэй. Аймгийн БСУГ нь сургуулийн Дэмжлэгийн багуудыг байгуулж, хурал хийх өдрийг товлон салбар Комисс нь хэлэлцэж хүүхдүүдийг сонгох, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэх, хамрагдах хүмүүстэй холбоо барих зэрэг хурлын бэлтгэл, зохион байгуулалтыг хариуцна.

Зөвлөлийн хурлын зохион байгуулалттай холбоотой хэд хэдэн асуудлыг онцгойлон журамлаж өгсөн байна. Тухайн хурлаар хэлэлцэх хүүхдийн тооноос хамааран хурал хэдэн өдөр үргэлжлэхийг шийдэх ба нэг хүүхдийг хэлэлцэх хугацааг урьдчилан тогтоосон байна. Салбар комисс нь сургуулийн бэлтгэл бүлэгт бүртгүүлээгүй болон сургуульд хамрагдах насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн мэдээллийг БСУГ-т гаргаж өгнө.

Нэгэнт хурлаар орох хүүхдийн тоо, хурлын үргэлжлэх хугацаа тодорхой болсны дараа аймгийн БСУГ нь хурал зохион байгуулах төлөвлөгөө гаргана. Салбар комисс нь оролцох хүүхэд, тэдний асран хамгаалагч нарт хурлын товыг зарлаж мэдэгдэх асуудлыг хариуцна.

**Журмын 5.4-т** Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоож өгчээ. Эхлээд хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, цэцэрлэгийн багшаас хүүхдийн нөхцөл байдал, сурахтай холбоотой сонирхлыг нь сонсоно. Дараа нь сургуульд суралцахад учирч болох саад бэрхшээлийг ярилцаад тухайн нөхцөлд нийцтэй дэмжлэгийг тодорхойлж, Хурлын шийдвэрийн маягтад шийдвэрээ бичиж, баримтжуулна. Уг дэмжлэгийг хэрэгжүүлэхтэй холбоотой сургуулийн захиралд хандсан зөвлөмж боловсруулж, мөн Шийдвэрийн маягтад бичиж, баримтжуулна. Ингээд тухайн

хүүхдийн талаар Зөвлөлийн гарсан шийдвэр, сургуульд хандсан зөвлөмж нь албан ёсны баримт бичиг болно.

*Хөвсгөл аймгийн Засаг даргын  
2019 оны А/247 тоот захирамжаас*

**Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд  
хамрагдалтыг дэмжих зөвлөлийн ажиллах журам  
(үргэлжлэл)**

**Тав. Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын үйл  
ажиллагаа (үргэлжлэл)**

5.4. Сургуульд хамрагдалтыг дэмжих хурлын хэлэлцэх  
асуудлын дараалал

Хурлаар хүүхдийг дараах байдлаар хэлэлцэнэ. Үүнд:

- Тухайн хүүхдийн талаар асран хамгаалагч, цэцэрлэгийн багшаас мэдээлэл сонсоно.
- Сургуульд элсэхэд ямар бэрхшээл, асуудал байгааг оролцогчид ярилцана.
- “Сургуульд хамрагдалтыг дэмжих хурлын шийдвэрийн хуудас” маягтыг ашиглан сургуульд хамруулахад чиглэсэн дэмжлэгийн талаар хэлэлцэнэ.
- Сум, сургуулийн удирдлагын зүгээс шаардлагатай дэмжлэгийн агуулгыг хэлэлцэнэ.
- Хурлын шийдвэрийг Шийдвэрийн маягтад бичиж баталгаажуулан, тухайн сургууль, цэцэрлэгт илгээнэ.

Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл нь Монгол Улсад шинээр бий болж буй бүтэц учраас ажил хэргээ явуулахад нь дэм болгож аймгийн Засаг дарга журамдаа Зөвлөлийн хурлын шийдвэр, зөвлөмжийг баримтжуулах албан маягтуудыг багтаан баталсан байна.

*Хөвсгөл аймгийн Засаг даргын  
2019 оны А/247 тоот захирамжаас*

**Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд  
хамрагдалтыг дэмжих зөвлөлийн ажиллах журам  
(үргэлжлэл)**

**Тав. Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын үйл  
ажиллагаа (үргэлжлэл)**

- 5.5. Сургуульд хамрагдалтыг дэмжих хуралд ашиглах маягтууд
- Хүүхдийн үндсэн мэдээлэл: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын ашигладаг “Хүүхдийн хувийн хэрэг”-ийг ашиглана.
  - Сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас сургуульд илгээх мэдээллийн хуудас (Хавсралт 1).
  - Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрийн маягт (Хавсралт 2).

## 2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд тэгш хамруулах үйл ажиллагааны хэрэгжилт (Хөвсгөл аймгийн зарим жишээ)

Гарын авлагын энэ бүлэгт Хөвсгөл аймгийн холбогдох байгууллагаас боловсруулж хэрэгжүүлсэн зарим ажлын бодит жишээг оруулав.

**Жишээ 1. БСУГ-аас Журмын 4.1-ийн дагуу Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэв.**

№	Хийх ажил	Хугацаа	Байгууллага	Хариуцах эзэн
1	Зөвлөлийн журмыг хэрэгжүүлэгч субъектүүдэд таниулах сурталчлах ажлыг зохион байгуулах	2019 оны 5 сар	БСУГ	Ш.Отгон-Эрдэнэ
2	Зөвлөлийн гишүүд, Салбар комисс, БСУГ-ын мэргэжилтэн, ЕБС-иудын удирдлагыг Улаанбаатарт тусгай сургуулийн туршлага судлах арга хэмжээнд хамруулах	2019. 06.4-8	БСУГ ДЗОУБ	Д.Баасансүрэн Г.Дулмаахүү
3	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгаанд анализ хийж, ахуй амьдралын дэмжлэг шаардлагатай хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах		Салбар комисс ДЗОУБ	Ц.Оюун-Эрдэнэ Д.Баасансүрэн Бүрэнжаргал

Үргэлжлэл

4 “Зөвлөх ээж” үйл ажиллагааг хэрэгжүүлэх	БСУГ, ДЗОУБ, ХБХЭЭХ,	Д.Баасансүрэн Ч.Лхагвасүрэн Э.Эрдэнэсүрэн
5 Аймгийн засаг даргын “Оюунлаг Хөвсгөл” дэд хөтөлбөрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах тухай 6.18.87 заалтын хэрэгжилтэд мониторинг хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах	2019 оны 9-10 сар	Ч.Лхагвасүрэн Ш.Отгон-Эрдэнэ Д.Баасансүрэн
6 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хүртээмж, чанарын асуудлаар Нийтийн сонсгол зохион байгуулах	2019 оны 12 сард	Аймгийн ИТХ ХБХЭЭХ БСУГ, Дэмжлэгийн зөвлөл



**Жишээ 2. Сургуульд хамрагдалтыг дэмжих  
зөвлөлийн хурлын төлөвлөгөө**

№	Хийх ажил	Хугацаа	Байгуул- лага	Хариуцах эзэн
1	Салбар комиссын судалгаанд үндэслэн 6 настай шинээр сургуульд элсэх хүүхдүүдийн судалгааг гаргаж анализ хийх	5 сарын 6-7	БСУГ, Салбар комисс	Д.Баасансүрэн Ц.Оюун-Эрдэнэ П.Хуншагай
4	Мөрөн сумын ЗДТГ-тай хамтран хамран сургах тойргийн хүүхдүүдийг сургуульд бүртгүүлсэн эсэхэд хяналт хийх	5 сарын 8-10	БСУГ, Мөрөн сум	Д.Баасансүрэн Багийн засаг дарга нар
3	Холбогдох сум, сургуулийн удирдлага, эцэг эхэд хурлын зар хүргэх	5 сарын 15	АЗДТГ-ын НБХ, БСУГ	С.Нарантуяа Д.Баасансүрэн
4	Зөвлөлийн гишүүдийн өдрийн хоол, хуралд оролцогч хүүхдүүдэд хөнгөн цай өгөх асуудлыг шийдвэрлэх	5 сарын 20	БСУГ, ДЗОУБ	Д.Баасансүрэн Г.Дулмаахүү
5	Хурлын бэлтгэл ажлыг хэлэлцэх	5 сарын 14	БСУГ, Салбар комисс	С.Нарантуяа Ц.Оюун-Эрдэнэ Д.Баасансүрэн
6	Хурал зохион байгуулах байр бэлдэх	5 сарын 22	БСУГ	Д.Баасансүрэн Л.Нансалмаа

7	Хурлын шийдвэр болон хүүхдийн мэдээлэл агуулсан маягт бэлтгэх (хүүхдийн тоогоор)	5 сарын 17	Салбар комисс БСУГ	Ц.Оюун-Эрдэнэ Д.Баасансүрэн
8	Хурлын хөтөлбөр бэлтгэж гаргах	5 сарын 20	БСУГ	Ш.Отгон-Эрдэнэ Д.Баасансүрэн

### *Үйл ажиллагааны үр дүн*

2018 оны 5 дугаар сард аймгийн Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн анхдугаар өргөтгөсөн хурлыг зохион байгуулж, дараах үр дүнд хүрсэн:

- Тухайн жилд ЕБС-д элсэх хөгжлийн бэрхшээлтэй 39 хүүхдээс 25 хүүхдийг уг хуралд оролцуулан, сургуульд элсүүлэх шийдвэрийг гарган харьяа ЕБС-д илгээсэн бөгөөд өмнөх жилүүдтэй харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн элсэлт 2-3 дахин нэмэгдсэн.
- Сургуулийн удирдлага болон холбогдох хүмүүс тухайн хүүхдэд ямар дэмжлэг үзүүлэх талаар чиглэл өгч ярилцсан нь хүүхдийн цаашид суралцах боломж нөхцөлд бодит хувь нэмэр болсон.
- Хуралд БСШУЯ-ны мэргэжилтэн А.Гэрэлтуяа, Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагын мэргэжилтнүүд оролцож, мэргэжил арга зүйн чиглэлээр Зөвлөлийг чадавхжуулж ажиллав.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, сургууль, цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бодит дэмжлэг үзүүлэх зорилгоор

аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссоос кейс хэлэлцүүлэг зохион байгуулж байна.

Кейс хэлэлцүүлгийг хэрхэн зохион байгуулах вэ?

- Салбар Комиссын ажлын төлөвлөгөөнд улирал бүр нэг хүүхдийн тулгамдсан асуудлын талаар “кейс хэлэлцүүлэг” хийх ажил тусжээ.
- Кейс хэлэлцүүлгийг салбар Комиссын гишүүд хуваарийн дагуу хариуцан зохион байгуулж байна.
- Кейс хэлэлцүүлэг зохион байгуулах салбар Комиссын гишүүн хүүхдийн гэрт очиж, нөхцөл байдалтай танилцсаны үндсэн дээр кейсийг бэлдэж салбар Комисс, Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн гишүүдэд танилцуулна.
- Тухайн хүүхдийн кейс дээр салбар Комиссын гишүүд ICF ангилал ашиглан үнэлгээ хийж, хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөг гаргасны дараа хэлэлцүүлэг зохион байгуулна.
- Хэлэлцүүлгээр уг хүүхдэд ямар дэмжлэг шаардлагатай болохыг хэлэлцээд, уг дэмжлэгийг хэрэгжүүлэх хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулна.

Салбар комисстой хамтран анхны кейс хэлэлцүүлгийг 2019 онд 2 удаа зохион байгуулсан бөгөөд энэ арга хэмжээ нь салбар хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах нэг боломж болсон юм. Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл нь зөвхөн 1 дүгээр ангийн элсэлтээр ажлаа хязгаарлахгүйгээр асуудалд олон талаас хандах боломжийг олж харсан нь ач холбогдолтой байсан гэж оролцогчид дүгнэж байна.

## Кейс хэлэлцүүлгийн хөтөлбөр

2019 оны 1 дүгээр сарын19

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1	Нээж үг хэлэх	09:30-09:35	Ж.Ганболд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын дарга
2	Өмнөх кейс хэлэлцүүлгийн үр дүнг мэдээлэх	09:35-09:50	Ж.Мягмарнаран Салбар комиссын гишүүн, Хүүхдийн мэдрэлийн эмч
3	ICF-д суурилсан хөгжлийн үнэлгээ хийх талаар өмнөх мэдлэгээ сэргээн санах	09:50-10:00	Д.Баасансүрэн Салбар комиссын гишүүн, БСУГ
4	Кейс танилцуулах	10:00-10:15	Д.Баасансүрэн Салбар комиссын гишүүн, БСУГ
5	Сонгосон хүүхэд болон ээжтэй уулзах	10:15-10:30	Д.Баасансүрэн болон хүүхдийн ээж
6	Кейс дээр хэлэлцэж ICF-р хөгжлийн үнэлгээ хийх	10:30-11:00	Салбар комисс
7	Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах	11:00-11:30	Салбар комисс
8	Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөөг танилцуулан ярилцах	11:30-11:50	Д.Баасансүрэн Салбар комиссын гишүүн, БСУГ
9	Дүгнэлт	11:50-12:00	Ж.Ганболд Салбар комиссын дарга

Кейс хэлэлцүүлэгт сонгогдсон хүүхдийн тухай  
ерөнхий мэдээлэл

1. ... овогтой ..., 3 нас ... сартай, .... (хүйс)

№	Утга	Тайлбар
Нэг. Үндсэн мэдээлэл		
1	Хүүхдийн овог нэр	...овогтой ...
2	Нас, хүйс	3 нас .... сартай, ... (хүйс)
3	Төрсөн огноо	... оны ... сарын ... өдөр
4	Төрсөн газар	Нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг
5	Онош	Тархины саажилт
6	Хавсарсан бэрхшээл	-
7	Өсөлтийн түүх	
8	Жирэмсний үе	Хэвтрийн дэглэмтэй байсан.
9	Тээсэн хугацаа	7 сартайдаа ус нь гараад тогтоож чадаагүй дутуу төрсөн.
10	Төрсөн жин	1300 гр
11	Өсөлтийн явц	9 сартайд нь эмчид үзүүлж мэдсэн. 3 настайгаасаа муухан сууж эхэлсэн. 3 настайгаасаа хөлөө чирч мөлхөж эхэлсэн. Хөлд ороогүй, гэртээ том хүний хуучин тэргэнцэр дээр суудаг. Гадуур гарахдаа ээж, аав нь тэвэрч явна. 2 настайдаа ээж, аав гэх мэт цөөн хэдэн үгээр ярьж эхэлсэн. Одоо сайн ярьдаг. Хүүхдүүдтэй тоглох дуртай. Хоолоо өөрөө иднэ, жаахан асгадаг. Зурагт үзэх дуртай.

---

Хоёр. Амьдралын талаарх мэдээлэл

---

- |    |  |  |
|----|--|--|
| 12 | Ам бүл                                 | Аав, ээж, эгчтэйгээ амьдардаг. Эгч нь ...настай.   |
| 13 | Гэр бүлийн гишүү-<br>дийн ажил эрхлэлт | Аав нь ... ажил хийдэг, ээж нь гэртээ хүүхдээ хардаг, эгч нь ... сургуулийн ...-р ангид сурдаг.  |
| 14 | Гэр бүлийн дундаж<br>орлого            | Улирлын чанартай ажилтай үедээ сард 300,000-400,000 төгрөгийн орлоготой, өвөл айлын мод хөрөөдөх гэх мэт ажил хийж сард 200,000 орчим төгрөгийн орлого олдог.  |
| 15 | Амьдрах орчин<br>нөхцөл                | Айлын хашаанд гэрт амьдардаг. ...сумын ...-р хороонд түр оршин сууж байгаа. Хөдөө гарах бодолтой байгаа. Хүүхдээ цэцэрлэгт өгчихвөл сумандаа ээж нь ажил олж хийх бодолтой. Хүүхэд харах үйлчилгээнд явуулж үзсэн, том хүүхдүүдтэй хамт байсан зодуулсан юм шиг байсан хамраас нь их цус гарсан ирсэн тул явуулахаа больсон. Улсын цэцэрлэгт өгмөөр байна. |
| 16 | Гэртээ хөгжих<br>боломж                | Эгчтэйгээ хамт эвлүүлдэг тоглоомоор тоглодог. Зурагт үзэж, дуу сонсох дуртай.  |

---

Гурав. Хөгжлийн талаарх мэдээлэл

---

- |    |  |  |
|----|--|--|
| 17 | Цэцэрлэг<br>сургуульд<br>хамрагддаг эсэх | Хүүхэд харах үйлчилгээнд 4-5 удаа очсон.   |
| 18 | Материаллаг<br>орчин                     | Өөрт нь тохирсон тэргэнцэр хэрэгтэй байгаа, Ээж нь хүүхдээ хүнд бэрхшээлтэй, хөгжих явц удаан гэж боддог. Ээж нь хэт их эрхлүүлж, тэгчих байх, ингэчих байх гэж байнга анхаарал тавьж байдаг. Ээж хүүхэдтэйгээ аль болох тоглох, шинэ зүйл зааж өгөх гэж хичээдэг. |

- 19 Олон нийтийн хандлага Гадуур явахдаа тэвэрч явдаг, бие нь томроод хэцүү байдаг. Цэцэрлэгт явуулах гэж уулзсан, явдаггүй болохоор хэцүү гээд хүлээж аваагүй.
- 20 4 настай хүүхдийн хөгжилтэй харьцуулахад Маш их уйлдаг, уурладаг, заримдаа шөнө маш их уйлдаг, ээжээсээ салах дургүй, гадуур гарахаар нь дагаж уйлдаг. Өмдөндөө шээдэг, голдуу памперс хийдэг, хүндээр бие засахаа хэлнэ. Хүүхэлдэйн кино үзэх дуртай. Сайн ярина. Зүүн гараараа юм барьж чадахгүй, баруун гараараа харандаа барьж чаддаг.
- 21 Ээжийн ирээдүйн зорилго Өөрөө явдаг болоосой. Цэцэрлэгт явуулах, цаашлаад насанд нь сургуульд оруулах.
- 22 Салбар комиссын үзүүлсэн үйлчилгээний үр дүн Анх 2016 оны 1 дүгээр сарын 27-нд салбар комиссын хурлаар орж нийгмийн халамжийн үйлчилгээ авч эхэлсэн. Эмчээс зөвлөгөө авч, эмчилгээ сайн хийлгэх талаар зөвлөсөн, мөн халамжийн мөнгөө хүүхдийнхээ хөгжил, эрүүл мэндэд зориулж байхыг зөвлөсөн.
-

Хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Дэмжлэгийн зорилт	Хугацаа	Дэмжлэгийн агуулга	Хариуцах эзэн	Биелэлт
1	Цэцэрлэгт хамруулах	Нийгэмшүүлэх бие даалгах	3/1	7 хоногт 2-3 удаа	Д.Баасансүрэн Ж.Ганболд	Портеж хөтөлбөр, “Өвгөд” төвийн эмчийн сэргээн засах үйлчилгээнд намар болтол явуулаад цэцэрлэгт хамруулахаар шийдвэрлэсэн.
2	Портеж хөтөлбөрт хамруулах	Хөдөлгөөн бие даах чадварыг сайжруулах	3/1	14 хоногт 1 удаа 1 цаг	Ж.Ганболд	Хөдөлгөөн засалд “Өвгөд” төвийн Халтар эмч дээр хамруулж эхэлсэн. Портеж хөтөлбөрт хамруулж эхэлсэн.
3	Сэргээн засах эмчилгээнд хамруулах	Явах, хөл гарын хөдөлгөөний идэвх сайжрах	4/1-5/30	Ажлын 7 хоногт 1-2 удаа	Халтар (Өвгөд) Ч.Лхагвасүрэн	
4	Нэгдсэн эмнэлэгт зүү, сэргээн засах эмчилгээ	Шээс барих, бие даан шээдэг болох	6/1-9/1	1 сард 7-10 хоног нийт 3 удаа	Ж.Мягмарнаран Б.Оюунгэрэл	



Үргэлжлэл

№	Үйл ажиллагаа	Дэмжлэгийн зорилт	Хугацаа	Дэмжлэгийн агуулга	Хариуцах эзэн	Биелэлт
5	Өрхийн орлого нэмэгдүүлэх	Өрхийг тогтмол орлоготой болгох	4/1	4-р сарын 1 гэхэд ажилтай болгох	Ч.Лхагвасүрэн	Тухайн хувийн хэвшил болон сонгосон хүүхдийн аав, ээж нь зөвшилцөөгүй.
6	9 дүгээр сарын 1-ээс харьяаллын дагуу цэцэрлэгт хамруулах	Цэцэрлэгт тогтмол явуулах	9/1	9/1-ээс	Д.Баасансүрэн Ж.Ганболд	Эрхлэгчид урьдчилсан байдлаар хэлсэн байгаа.

Кейс хэлэлцүүлгийг удирдсан: БСУГ-ын мэргэжилтэн Д.Баасансүрэн

## **2.3. Сургуулийн Дэмжлэгийн багийн үйл ажиллагаа (Хөвсгөл аймгийн туршлага)**

### *Сургуулийн Дэмжлэгийн баг*

Сургуулийн Дэмжлэгийн багийг төслийн хүрээнд “Ирээдүй 21-р зуун”, “Титэм” сургуулиуд дээр 2018 онд байгуулж, үйл ажиллагааг нь туршин хэрэгжүүлэв.

ХНХ, БСШУС, ЭМ-ийн Сайдын хамтарсан А/304, А/699, А/460 тоот “Заавар маягт батлах тухай” тушаал, 2019 оны БСШУС-ын Сайд А/292 тоот тушаалаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журам” зэргийг үндэслэн Сургуулийн Дэмжлэгийн багийн үйл ажиллагааг зохион байгуулж байна. Дэмжлэгийн багийн бүрэлдэхүүнд сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, сургуулийн эмч, тусгай дэмжлэгийн төвийн багш, анги удирдсан багш, мэргэжлийн багш нар багтана.

Сургуулийн дэмжлэгийн баг нь дараах үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

- Суралцагчдаас тусгай дэмжлэг шаардлагатай хүүхдийг эрт илрүүлэх;
- Тусгай дэмжлэг шаардлагатай хүүхдүүдийн бодит байдлыг судалж мэдэх;
- Эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлт болон аймгийн Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэрт үндэслэн Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулах;
- Тухайн хүүхдэд зориулсан тусгай дэмжлэг болон Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний талаар сургуулийн нийт багш, ажилтанд мэдээлэх, ойлгуулах ажлыг зохион байгуулах;

- Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар санаачилгатай ажиллах зэрэг болно.

Сургуулийн Дэмжлэгийн багийн үйл ажиллагааны чиглэлийг БСШУСЯ-аас гаргасан аргачлалд тодорхой заасан бөгөөд үүнийг дараах зургаас харна уу.

### БСШУСЯ-аас гаргасан аргачлал

#### 4. Сургууль дээр хэрэгжүүлэх боломжтой дэмжлэгийн агуулга



Хөвсгөл аймгийн Сургуулийн дэмжлэгийн багийн үйл ажиллагааны талаарх зарим жишээг дурдвал:

**Жишээ 1. Сургуулийн Дэмжлэгийн багийн  
жилийн ажлын төлөвлөгөө**

№	Хийх ажил	Хугацаа	Хамтрах байгууллага	Хариуцах эзэн
1	Тохирох хэрэглэгдэхүүний загвар боловсруулах уралдаан зохион байгуулах	1-р улирал	БСУГ	Сургуулийн захиргаа, Дэмжлэгийн баг
2	Сургуулийн орчныг түгээмэл загвараар бүрдүүлэх	1, 2-р улирал	Аймгийн сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл, эцэг эх, олон нийт	Сургуулийн захиргаа, Дэмжлэгийн баг
3	Сэргээн засах үйлчилгээнд хүүхдүүдээ хамруулах	2, 4-р улирал	ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, ХХҮГ	Дэмжлэгийн баг
4	Кейс хэлэлцүүлэг хийх арга зүйн сургалт, дадлага ажил хийх	3-р улиралд	Салбар комисс	Дэмжлэгийн баг, ЗАН
5	Кейс хэлэлцүүлэг хийх	3-р улиралд	Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл, салбар комисс	Дэмжлэгийн баг
6	Дэмжлэгийн багийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	1-р улиралд	БСУГ	Сургуулийн захиргаа, Дэмжлэгийн баг
7	Сургуулийн зөвлөх эцэг эх бэлтгэх сургалт зохион байгуулах	2-р улиралд	БСУГ, ХБХЭЭХ	Сургуулийн захиргаа, Дэмжлэгийн баг

## Жишээ 2. Дэмжлэгийн багийн хурлын төлөвлөгөө

Сар	Сургуулийн Дэмжлэгийн багийн хурал
9	<p><i>1 дүгээр хурал</i></p> <ol style="list-style-type: none"><li>1. Тухайн жилд дэмжлэг хэрэгцээтэй хүүхдүүдийг тодорхойлон гаргаж, хүүхдүүдийн талаарх ерөнхий мэдээллийг хэлэлцэн, дэмжлэг үзүүлэх чиглэлээ шийднэ (ГСТ боловсруулах эсэхээ нэг бүрчлэн шийднэ).</li><li>2. Тухайн жилийн сургалт хийх төлөвлөгөө гаргана (багш нарт зориулсан, орон нутаг, эцэг эхчүүдэд зориулсан).</li></ol>
10	<p><i>2 дугаар хурал</i></p> <p>Нэгдүгээр хурлаар ГСТ хэрэгцээтэй гэж шийдвэр гарсан хүүхдүүдэд зориулж боловсруулсан ГСТ-г мэдээлж, нягтлах (АУБ-ийг оролцуулна). Шинээр элссэн сурагчдаас дэмжлэг хэрэгцээтэй байгаа хүүхдийг тодорхойлж, хүүхдүүдийн талаарх ерөнхий мэдээллийг хэлэлцэн, дэмжлэг үзүүлэх чиглэлээ шийднэ (ГСТ боловсруулах эсэхээ нэг бүрчлэн шийднэ).</p>
11	<p><i>3 дугаар хурал</i></p> <p>Тухайн улирлын богино хугацааны зорилтыг хүүхэд бүрээр хэлэлцэж, сайжруулна. Кейс хэлэлцүүлэг хийнэ.</p>
12	<p><i>4 дүгээр хурал</i></p> <p>ГСТ-ний хэрэгцээтэй богино хугацааны зорилтын хэрэгжилт, үр дүн Аймгийн Сургуульд хамрагдалтыг дэмжих Зөвлөлтэй хамтран мониторинг хийж сайн туршлагаа хуваалцан, тулгамдсан асуудлыг шийдвэр гаргагчдад хүргүүлнэ.</p>
13	<p><i>5 дугаар хурал</i></p> <p>ГСТ-ний хэрэгжилтийн байдал</p>
14	<p><i>6 дугаар хурал</i></p> <p>Жилийн эцсийн өргөтгөсөн хурал. Үнэлгээ, сайжруулалтыг хэлэлцэнэ.</p>


Сургуулийн Дэмжлэгийн багийг ажиллуулснаар дараах үр дүн гарч байна. БСШУС-ын Сайдын А/155 дугаар тушаалаар батлагдсан Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх явцдаа хүүхдийн сурч боловсрох, чанартай боловсрол эзэмших, сургуулийн болон сургалтын орчинд хүүхдийн эрхийг хүндэтгэх, хангах шинэ хандлагыг төлөвшүүлэхэд чухал хувь нэмэр оруулж, арга зүйн дидактик шийдлүүдийг оновчтой байдлаар дамжуулан сургуулийн хамт олон багаараа ажиллах арга хандлагыг бий болгож, тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийг сургуульд тэгш хамруулах боломж бүрдэж байна.

### **БҮЛЭГ 3. ТӨСӨЛД ХАМРАГДСАН СУРГУУЛИЙН ТУРШЛАГА**

Хөвсгөл аймгийн “Ирээдүй 21-р зуун” сургууль нь Дэмжлэгийн багаа байгуулахаас ажлаа эхэлжээ. Уг сургуулийн Дэмжлэгийн багийн ахлагчаар нийгмийн ажилтан томилогдож, бүрэлдэхүүнд нь сургуулийн захирал, дунд болон бага ангийн сургалтын менежер, тусгай хэрэгцээт боловсролын дэмжлэгийн төвийн багш, сургуулийн эмч, эмчилгээний биеийн тамирын багш, хөгжмийн багш, зураг урлалын багш, заах аргын нэгдлийн ахлагч, анги удирдсан багш зэрэг 11 хүн багтжээ. Сургуулийн Дэмжлэгийн багийн бүрэлдэхүүнийг захирлын тушаалаар баталсан байна.

Тусгай хэрэгцээт боловсролын дэмжлэгийн төвд хамрагдан хичээллэж байгаа хүүхдийн тоо, тэдний бэрхшээлийн байдлаас хамааран сургуулийн Дэмжлэгийн багийн гишүүдээс 3-4 хүнийг сольж ажиллуулж болно. Ингэснээр бусад багш нарын тусгай хэрэгцээт боловсролын талаарх мэдлэг, хандлагад түргэн хугацаанд өөрчлөлт гарч, багшаас багшид дамжин тэлэх сайн нөлөө гарсан байна.

### Дэмжлэгийн баг байгуулах тухай тушаал, бүрэлдэхүүн


  
**МОНГОЛ УЛСЫН ГАВЬГАТ БАШДБАТСҮҮРИЙН НЭРЭМЖИТ  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН БҮРЭН ДУНД Ц СҮРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

Бат 2018 оны 09 сарын 21 өдөр Өдөр М/Н Мөрөн


**Сургууль дэмжих зөвлөл байгуулах  
тухай**

Бага Дунд Боловсролын тухай хуулийн 20.1.6, 20.2.6 заалтуудыг үндэслэн **ТУШААЛ** нь:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах зорилгоор нээгдсэн тусгай зориулалттай боловсролын төмөр хөгжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах, дэмжих, хамтран ажиллах сургууль дэмжлэгийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:  
 Багийн ахлагч С.Мөнхболд/Захирал/  
 Гишүүн  
 1. Дэлгэлсүрэн/АНТ-ийн сургалтын менежер/  
 2. Сономжав/Байгалийн ухааны сургалтын менежер/  
 3. Бурмаа/Иргэдийн ажилтан/  
 4. Балтуун/Иргэдийн ажилтан/  
 5. Арсланзүүр/Биологийн танинч багш/  
 6. Мятмарсаяа/Зураг зүйн багш/  
 7. Оюу-эрдэнэ/Сургуулийн эмч/  
 8. Болор-эрдэнэт/Хөгжүүлэх төвийн багш/  
 9. Энхтүүл/Мөрөн сумын байгалийн хармуудан мэргэжилтэн/  
 10. Эрдэнэжав/Мөрөн сумын иргэдийн ажилтан/
- Хөгжүүлэх сургалтын танимд ажилт зохион байгуулах, төвийн үйл ажиллагааг төлөвлөн, хөтөлбөр төлөвлөгөө гарган хэлэлцжэ батлуулан багш С.Болор-эрдэнэтэй хамтран ажиллаж ажил хэргийн алаагч гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  СМӨНХБОЛД

My doc. TUSHAAL.


  
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРЭЭДҮЙ ХХИ ЗУУН ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2018 оны 09 сарын 21 өдөр Дугаар А/10 Мөрөн

**Сургууль дэмжих зөвлөл байгуулах  
тухай**

Бага Дунд Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, 20.2.6 заалтуудыг үндэслэн **ТУШААХ** нь:


- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах зорилгоор нээгдсэн "Тусгай хэрэгцээт боловсрол"-ын төвд хөгжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах, дэмжих, хамтран ажиллах сургууль дэмжлэгийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай!  
 Үүнд:  
 Багийн ахлагч: З.Ариунтөгс /Иргэдийн ажилтан/  
 Гишүүн: Ц.Баярсайхан /Захирал/  
 М.Даваа /Сургалтын менежер/  
 Д.Хишигжаргал /Сургалтын менежер/  
 Ц.Бэнэрчиг /Сургалтын менежер/  
 А.Түмэнжаргал /Сургуулийн эмч/  
 Б.Энхжаргал /Хөгжүүлэх төвийн багш/  
 Ц.Ганбаатар /Хөгжүүлэх төвийн багш/  
 С.Отгонтөгс /Биологийн танинч багш/  
 Ц.Баянжаргал /Зураг зүйн багш/  
 М.Пүрэвцэцэг /Дуу хөгжмийн багш/  
 А.Баасансүрэн /ББЗАН-ийн ахлагч/  
 Г.Золжаргал /Анги удирдсан багш/
- Хөгжүүлэх сургалтын танимд ажилт зохион байгуулах, төвийн үйл ажиллагааг төлөвлөн, хөтөлбөр төлөвлөгөө гарган хэлэлцжэ батлуулан "Хөгжүүлэх төв"-ийн багш/Б.Энхжаргал/-тэй хамтран ажиллахыг "Ажлын хэсэг"-ийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай!

ЗАХИРАЛ  Ц.БАЯРСАЙХАН

D/Zahiral/tushaal.2018

Захирлын тушаалаар байгуулсан Дэмжлэгийн баг нь жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, Дэмжлэгийн багийн хурлаар хэлэлцүүлэн эцэслэж, сургуулийн захирлаар батлуулж ажиллах туршлагатай болоод байна.



БАТЛАВ				
ЗАХИРАЛ  С.МӨНХБОЛД				
<b>МУГБагш Д. Батсуурийн нэрэмжит ТИГЭМ ерөнхий боловсролын сургуулийн сургууль дэмжих зөвлөлийн ажлын төлөвлөгөө</b>				
д/д	Зохион байгуулагдах ажил	Сар	Ганцаарчилсан хурал	Сургуулийн дотоод сургалт
1	СДЗ-ийг захирлын тушаалаар батлах	4-р сард		СДЗ-лөл байгуулах түүний оролцоо үүргийн талаар сургалт
2	1. 1-р хурал зохион байгуулах. 2.30 хүүхдийн жагсаалт гаргах. 3. IF1; IF2 - ыг 30 хүүхдээсээ сонгож хийх	5-р сард		Анги удирдсан багш бүрээс сурахуйн бэрхшээлтэй хүүхдийн судалгаа гаргах СДЗ-ийн хурал зохион байгуулах
3	2-р хурал зохион байгуулах IF-гээ баталгаажуулах	8-р сард		СДЗ-өөрөө
4	1. Шинээр ирэх хүүхдүүдээс IF1; IF2-оо сонгох 2. 3-р хурал зохион байгуулах	10-р сард		1-р ангид элсэн суралцаж байгаа хүүхдүүдээс судалгааг авч нэгтгэх хэлэлцэх. СДЗ-рөө СДЗ-өөрөө
5	4-р хурал зохион байгуулж Хүүхдүүдээ баталгаажуулах	11-р сард		СДЗ-өөрөө
6	1. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд явцын үнэлгээ хийх эргэн харах. 2.5-р хурал зохион байгуулах	1-р сард		СДЗ болон Жайка төслийн багтай хамтарсан хурал зохион байгуулах.

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН НИЙГМИЙН АЖИЛТАН Т.БУРМАА

Эхний үед сургуулийн Дэмжлэгийн баг нь анхны хурлаа тухайн оны 5 дугаар сард хийж, ирэх жилд Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөтэй хичээллэх хүүхдүүдийг сонгон хэлэлцэж байсан. Гэвч бодит байдалд 9 дүгээр сард хичээл эхлэхэд шилжилт хөдөлгөөний улмаас хүүхэд нэмэгдэж, хасагддаг байдалтай уялдуулан 2019 оноос анхны хурлаа 9 дүгээр сард хийдэг болжээ. Энэ үед үйл ажиллагааны төлөвлөгөөгөө шинэчлэн батлуулсан байна.

Өөрчлөн сайжруулсан төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах эзэн	Тайлбар
1	Сургууль дээр Дэмжлэгийн баг байгуулах		VIII сарын 4-р 7 хоногт	СДБ-ийн ахлагч, ТХБ-ын төвийн багш	Захирлын тушаал гаргах.
2	Тусгай дэмжлэг шаардлагатай хүүхдийн судалгааг гаргах, нэгтгэх		IX сарын 1-р 7 хоногт	ТХБ-ын төвийн багш, бүх АУБ нар	ГСТ-тэй хичээллэх хүсэлт гаргасан сурагчдыг тодруулна.
3	Бодит байдлын судалгааг хийх		IX сарын 1-р 7 хоногт	Хүсэлт оруулж буй АУБ нар	А/155 маягтын дагуу Хүүхэд нэг бүрээр гаргана.
4	Хурал-1	Бодит байдлын судалгааг хүүхэд нэг бүрээр хэлэлцэх	IX сарын 2-р 7 хоногт	Хүсэлт оруулж буй АУБ нар СДБ	- ГСТ1, ГСТ2-ыг сонгох - Урт хугацааны зорилгыг тодорхойлох; - Хариуцах хүнийг томилох.
5	ГСТ-г боловсруулах, батлах		IX сарын 2, 3-р 7 хоногт	Сонгогдсон хүүхдийн АУБ, баг	ГСТ1, ГСТ2-ыг бичиж боловсруулахад ТХБ-ын багш дэмжлэг үзүүлэх, хамтрах.

Үргэлжлэл

№	Үйл ажиллагаа	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах эзэн	Тайлбар
6	ГСТ-ний I улирлын хэрэгжилт	I улиралд	Сонгогдсон хүүхдийн АУБ нар, баг	Тохируулгат орчин, тохирох хэрэглэгдэхүүн сонгох, бэлдэж боловсруулах.	
7	Хурал-2	Шинээр элсэн орсон хүүхдүүдийн дотор байгаа ТХБ-ын дэмжлэг шаардлагатай хүүхдийн талаар	X сарын 1-р 7 хоногт	1-р ангийн багш нар, СДБ	- Шинэ хүүхэд байгаа бол энэ төлөвлөгөөний №2-5 дахь үйл ажиллагаа; - Бусад хүүхдийн ГСТ-г эргэн харах.
8	Хурал-3	1-р улирлын богино хугацааны зорилтын хэрэгжилт, 2-р улирлын зорилт	XI сарын 2-р 7 хоногт	ГСТ-өөр ажиллаж буй багш нар, багийн гишүүд	Аймгийн салбар комисс, Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн кейс хэлэлцүүлэгт хүүхэд оруулах.
9	ГСТ-ний II улирлын хэрэгжилт	II улиралд	Сонгогдсон хүүхдийн АУБ нар, баг	Тохируулгат орчин, тохирох хэрэглэгдэхүүнийг сайжруулах, баяжуулах.	

Үргэлжлэл

№	Үйл ажиллагаа	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах эзэн	Тайлбар
10	Хурал-4	- 2-р улирлын БХЗорилгын хэрэгжилт, 3-р улирлын зорилт - Дэмжлэгийн явцын мониторинг	I сард	СДБ, БСУГ, Аймгийн Сургуульд хамрагдалтыг дэмжих Зөвлөл, салбар комисс, ХБХЭХолбоо ТББ, бусад	- Сайн туршлага дотроосоо түгээх; - Сайжруулах санааг гаднаас авах; - Ур чадварын болон нэмэгдэл хөлсний талаар.
11	ГСТ-ний III улирлын хэрэгжилт		III улиралд	Сонгогдсон хүүхдийн АУБ нар, багийн гишүүд	Тохируулгат орчин, хэрэглэгдэхүүнийг сайжруулах, баяжуулах.
12	Хурал-5	3-р улирлын богино хугацааны зорилтын хэрэгжилт, 4-р улирлын зорилт	III сарын 3-р 7 хоногт	Сургуулийн Дэмжлэгийн баг	ГСТ-г эргэн харах, Тохируулгат орчин, хэрэглэгдэхүүнийг сайжруулах, баяжуулах.

Үргэлжлэл

№	Үйл ажиллагаа	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах эзэн	Тайлбар
13	ГСТ-ний IV улирлын хэрэгжилт		IV улиралд	Сонгогдсон хүүхдийн АУБ, баг	Тохируулгаг орчин, хэрэглэгдэхүүнийг сайжруулах, баяжуулах.
14	Хурал-6 Өргөтгөсөн хурал	ГСТ-ний зорилгын хэрэгжилтийн үнэлгээ, сайжруулалт	V сарын дунд	Сонгогдсон хүүхдийн АУБ, СДБ Эцэг эхийн төлөөлөл	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэд бүрийн ахиц амжилт, ГСТ-ний хэрэгжилтийн үр дүн;</li> <li>- Анги төгсөх, дэвших асуудлыг шийдвэрлэнэ;</li> <li>- Эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгааг төстгээр авах, санал хүсэлт;</li> <li>- Ажилласан багш нарын сэтгэл ханамж, санал хүсэлт;</li> <li>- Удирдлагын сэтгэл ханамж, урамшуулал болон шүүмж гэх мэт.</li> </ul>

*Тусгай дэмжлэг шаардлагатай хүүхдийн судалгааг гаргах, нэгтгэх*

ТХБ-ын төвийн багш нь хичээлийн жилийн эхэнд анги удирдсан бүх багшаас доорх маягтын дагуу мэдээлэл авч, нэгтгэдэг.

**Тусгай хэрэгцээт дэмжлэг авах шаардлагатай  
хүүхдүүдийн судалгаа**

*(үнэн зөв хариулж, хариуцлагатай хандана уу)*

2019.09.03

Анги \_\_\_\_\_

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлаар орж онош тогтоолгон, хөгжлийн бэрхшээлтэй болохыг шийдвэрлэсэн хүүхдийн тоо \_\_\_\_\_

Эдгээр хүүхдийн нэрс: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

*(Эрүүл мэндийн картыг үндэслэнэ)*

Үүнээс халамжийн тэтгэмжид хамрагдсан хүүхдийн тоо \_\_\_\_\_

Эдгээр хүүхдийн нэрс: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

*(Эрүүл мэндийн карт дээрх шийдвэрийн  
хуулбарыг хавсаргана)*

2. Онош тогтоолгох шаардлагатай байгаа хүүхдийн тоо \_\_\_\_\_

Эдгээр хүүхдийн нэрс: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

3. Сурахуйн бэрхшээлтэй хүүхдийн тоо \_\_\_\_\_

Эдгээр хүүхдийн нэр: \_\_\_\_\_

---

4. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр (хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол зэрэг нэг болон хэд хэдэн судлагдахуунаар, биеийн хөгжлийн байдлаар, харилцаа нийгэмшихүйн байдлаар, өөртөө үйлчлэх чадвараар гэх мэт) хөгжүүлэх хүсэлт гаргах хүүхдийн тоо \_\_\_\_\_

Эдгээр хүүхдийн нэр: \_\_\_\_\_

---

(Асуулт 1-ээс 3-т нэр бичигдсэн хүүхдүүдээс  
сонгон хүсэлт гаргана)

Анги удирдсан багшийн нэр \_\_\_\_\_

\_\_\_\_\_

Гарын үсэг

Төвийн багш сургуулийн Дэмжлэгийн багийн гишүүний хамтаар тусгай дэмжлэг шаардлагатай хүүхдүүдийн судалгааг нэгтгэдэг бөгөөд судалгааны мэдээллийг хэрхэн нэгтгэж байгааг доор загвар хүснэгтээр жишээлж харууллаа.

Тусгай хэрэгцээт боловсролын дэмжлэг шаардлагатай хүүхдийн судалгаа											
"Ирээдүй XXI зуун" ЕБС										19.09.07	
№	Анги	АУБ-ийн нэр	ХБ-тэй хүүхдийн хүүхдийн тоо	Хүүхдийн нэр	Үүнээс халамжийн тэтгэмжид хамрагдсан хүүхдийн тоо	Онцш тогтоолгох шаардлагатай байгаа ХБ-тэй хүүхдийн тоо	Хүүхдийн нэр	Сурахуйн болон зан үйлийн бархшээлтэй хүүхдийн тоо	Хүүхдийн нэр	ГСТ-өөр хөржүүлэх хүсэлт гаргах хүүхдийн тоо	Хүүхдийн нэр
1	2a	Багш 1	1	хүүхдийн нэр	1	1	хүүхдийн нэр	0		1	хүүхдийн нэр
2	3b	Багш 2	0		0	0		2	хүүхдийн нэр	1	хүүхдийн нэр
3	4в	Багш 3	0		0	1	хүүхдийн нэр	1	хүүхдийн нэр	1	хүүхдийн нэр
4	7b	Багш 4	1	хүүхдийн нэр	0	2	хүүхдийн нэр	3	хүүхдийн нэр	5	хүүхдийн нэр
							хүүхдийн нэр		хүүхдийн нэр		хүүхдийн нэр
							хүүхдийн нэр		хүүхдийн нэр		хүүхдийн нэр
							хүүхдийн нэр		хүүхдийн нэр		хүүхдийн нэр
...	...	...	0		0	0		0			
31	12b	Багш 31	0		0	0		0	0		
			...		...	4		6	бүгд ....	38	
Судалгааг нэгтгэсэн ТХБ-ын төвийн багш Б.Энжжаргал											

Мэдээллийн нэгтгэлээс Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөтэй суралцахаар хүсэлт гаргасан хүүхдүүдийг ялган авч, хурлаар оруулахаар бүртгэлийг бэлдэнэ.

Хурлаар орох хүүхдийн бүртгэл

19.09.08

Д/Д	Нэр	Хүйс	Төрсөн огноо	Нас (Авто)	Анги	АУБ	Гэрийн хаяг/баг/	Бэрхшээл/асуудал	Эцэг эхийн холбогдох угас	тайлбар
1	хүүхэд 1	эр	13.06.01	7	1a	Багш 1	01.01.01	суралцахуйн		
2	хүүхэд 2	эр	13.03.03	7	1b	Багш 2	02.02.02	бие эрхтний		
3	хүүхэд 3	эр	12.04.04	8	1b	Багш 2	03.03.03	сонсголын		
4	хүүхэд 4	эр	11.05.05	9	2a	Багш 3	01.01.02	харааны		
5	хүүхэд 5	эр	10.03.03	10	2a	Багш 3	01.01.03	суралцахуйн		ахуйгаас хамаарсан
6	хүүхэд 6	эр	10.04.04	10	2b	Багш 4	02.02.01	тархины харвалт		
7	хүүхэд 7	эр	09.02.02	11	4в	Багш 5	02.04.04	хэл ярианы гэх мэт		
38	хүүхэд 38	эм	05.04.22	15	10b	Багш 15	01.10.01	бие эрхтний		
ТХБ-ын төвийн багш Б.Энжжаргал										

Сургуулийн Дэмжлэгийн багийн хурлаар танилцуулах сурагчдын жагсаалтад багтсан хүүхэд нэг бүрээр Бодит байдлын судалгааг анги удирдсан багш, тусгай хэрэгцээт боловсролын багштай хамтарч БСШУС-ын Сайдын А/155 тушаалын хавсралт загварын дагуу боловсруулж бэлтгэнэ. Энэ мэдээлэл нь Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний эхний хэсэгт бөглөгдөнө.



Энэхүү эхний хэсгийг гүйцэтгэхийн тулд хүүхдийн төрсний гэрчилгээ, өсөлт бойжилтын ягаан дэвтэр, эрүүл мэндийн дэвтэр, карттай танилцаж, хүүхдийг хичээлийн үед болон хамт олны дунд судлан ажиглана.

БАТЛАВ Сургалтын менежер ...../Д.Хишигжаргал/

**ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

<b>I. Сурагчийн бодит байдлын судалгаа</b>	
Сургуулийн комиссын хуралдааны огноо 2018.09.12	Сургуулийн эмнэлэг сурган хүмүүжүүлэх комиссын үнэлгээ, дүгнэлт:
Сурагчийн овог, нэр	..... огноо: □□□□□□□□
Регистрийн дугаар:	-Онош: <input type="checkbox"/> Оюуны хөгжлийн; <input type="checkbox"/> Харааны; <input type="checkbox"/> Тулгуур эрхтний; <input checked="" type="checkbox"/> Сонголын; <input type="checkbox"/> Аутизм; <input type="checkbox"/> Даун; <input type="checkbox"/> Хэл яриа; <input type="checkbox"/> Сурацхуй; <input type="checkbox"/> Сэтгэл хөдлөл; <input type="checkbox"/> бусад
Сургуульд элсэн орсон огноо, НТБ-оор, Хүүхдийн ордны төвд хамрагдаж байгаад 2016 оноос Ирээдүй XXI зуун ЦС-ийн ТХБ-ын Төвд явдаг байсан. 2018.09.03-ны өдрөөс 96 ангид орж суралцаж эхэлсэн (17нас)	-Дагалдах өвчин, эмгэгийн тухай мэдээлэл: <b>Сонсох болон хэл ярианы бэрхшээлтэй, цусны өвчтэй</b>
Анги: 9 бүлэг:Б Хүйс: Төрсөн огноо:2001-12-28	
Ам бүлийн тоо	Хамт амьдардаг гэр бүлийн гишүүд
Гэр бүлийн харилцааны төлөв байдал: Эцэг эхийн хайр халамж, харилцаа анхаарал маш сайн.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын комиссын шийдвэр: ЕБС-д тэгш хамруулан сургаж хамт олны дунд нийгэмшүүлэх хөгжүүлэх чийрэгжүүлэх
Цэцэрлэгт явсан эсэх (Тийм/Үгүй). -Хэрвээ тийм бол цэцэрлэгийн нэр: -Хэрвээ үгүй бол яваагүй шалтгаан: Ярьдаггүй, сонсдоггүй учраас яваагүй.	Эцэг, эх /асран хамгаалагч/-ийн нэр Холбоо барих утас: мэйл хаяг: Байхгүй
Оршин суугаа хаяг: Хөвсгөл аймгийн Мөрөн	Эрүүл мэндийн байгууллагын үзлэгт орж, оношлуулсан эсэх (Тийм/ Үгүй) -Хэрвээ тийм бол, Онош тавьсан эрүүл мэндийн байгууллагын нэр: Нэгдсэн эмнэлэг -Онош: Төрөлхийн сонсголтгүй -Үнэлгээний үр дүн: Эрүүл мэндийн байгууллагын хяналтад байдаг эсэх: (Тийм/ Үгүй); -Тийм бол тухайн эрүүл байгууллагын нэр, тавигдсан онош, хяналтын давтамж: Нэгдсэн эмнэлгийн дотор, чих хамаар хоолойн эмчид улиралд 1 удаа

Төрсөний дараахь /0-24 сар хүртэл/ үеийн хөгжлийн түвшингийн онцлог байдал	Хэвийн: Биеийн өсөлт хөгжил хэвийн боловч төрөлхийн сонсголтгүй байснаас, ярих чадвар сайн хөгжөөгүй.	
Сургуульд бэлтгэгдсэн байдал /2-5 нас/:	Гэртээ зураг зурах дуртай байсан	
ГСТ-д хамрагдах үеийн хөгжлийн түвшингийн байдал:	Өөртөө үйлчлэх энгийн чадварууд	Өөрийн бие даах чадвар маш сайн, Нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй
	Хэл яриа, танин мэдхүй, тоо тоолол	Танин мэдэх чадвар дунд, анхаарал төвлөрөлт сайн. Ярьдаггүй, сонсдоггүй. Суурь боловсрол эзэмшилт сайн биш ч, хуулан бичих, энгийн тоон үйлдлүүдийг хийдэг. Үгийг ойролцоо авнагаар дохионы хамт дуудаж хэлдэг. Уншсанаа ойлгодог.
	Нийгэмшихүй	Бусадтай зөв харьцаж найзлах нөхөрлөх чадвар сайн, Өөрийн БИ давамгайлах хандлагатай байсан нь засарч байгаа. 2017/2018 оны аймгийн БҮТЭЭЛЧ СУРАГЧ. Гар зургийн үзэсгэлэнгэ сургууль, аймагт гаргасан. Бусдад их санаа тавьдаг, халамжлах дуртай. Гар урлалын сургалтад ээж нь хамруулсан. УБ хотод Сэргээн засах үндэсний төвийн дохионы сургалтад хамрагдсан.
	Бие бялдар, хөдөлгөөн	Бие бялдрын хөгжил сайн, гүйж, тоглох зэрэгт ямар ч саадгүй. Гэвч ачаалал ихэдвэл цусны өвчин сэдэрдэг. Зураг, бүжгээр уралдаан тэмцээнд сайн оролдог. Аймгийн ЗӨНГИЙН ОДОД 2018 наадмын ГОЦЛОЛ БУЖГИЙН хүрэл медаль.
	Анги удирдсан багшийн тодорхойлолт	Албан бус боловсролоор олон жил суралцсан учраас оюуны хурд багатай, хоцрогдол ихтэй. Харин эцэг эхийн анхаарал халамж сайн болохоор хандлага зөв, их зүтгэлтэй, нийгэмшүүлэхэд хялбар байна.
Оролцогч талуудын хүсэл, зорилго	Сурагч:	/мөрөө хавчив/
	Эцэг эх /асран хамгаалагч/:	Үе тэнгийнхэнтэйгээ адилхан байж, өөрөөрөө бахархаж, баяр хөөртэй байгаасай
	Багш:	Хоцрогдлоо өөрийнхөө хэмжээнд нөхөж, үе тэнгийнхэнтэйгээ мөр зэрэгцэн сургуулийн амьдралас аз жаргалыг мэдэрч байгаасай

ТХБ-ын төвийн багш Б.Энхжаргал  
Хүлээн авч буй 96 ангийн АУБ Г.Гэрэлмаа

Салбар комиссын шийдвэр, эцэг эхтэй ярилцах замаар хүүхдийн боловсролын хэрэгцээ, сургуульд сурахтай холбоотой хүсэлтийг тодруулан тэмдэглэж авахын зэрэгцээ мөн хүүхдийн өөрийнх нь хүсэл, сонирхлыг асууж тэмдэглэж авна. Цуглуулсан бүх мэдээллийг сайтар судалж, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахад ашиглана.

Ингээд сургуулийн Дэмжлэгийн багийн хурлаар танилцуулж хэлэлцүүлэх хүүхэд нэг бүрийн материалыг анги удирдсан багш бэлдэж, Багийн хурлыг хуралдуулна. Сургуулийн Дэмжлэгийн багийн тухайн хичээлийн жилийн эхний хурлаар асуудал хэлэлцүүлж буй анги удирдсан багш нар хүүхэд нэг бүрийн бодит байдлын судалгааг дэлгэрэнгүй танилцуулсны дараа Дэмжлэгийн баг хэлэлцэн, анги удирдсан багшаас асуулт асууж, тодруулга авна. Тухайн хүүхдийн талаар хэлэлцсэний дараа Дэмжлэгийн баг нь дараах шийдвэрийг гаргана. Үүнд:

- Тухайн сурагч Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөтэй хичээллэх шаардлагатай эсэх;
- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөтэй хичээллэх шаардлагатай бол ГСТ1, ГСТ2-ын аль болохыг хэлэлцэж, оновчтой сонгох;
- Хүүхдэд хэн (багш, ажилтан) ямар чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллахыг тодорхойлох;
- Урт хугацааны зорилгыг тодорхойлох зэрэг болно.

Дэмжлэгийн багийн хурал, хэлэлцүүлэг хэрхэн явагддагийг дараах Хурлын тэмдэглэлээс үзнэ үү.

“Ирээдүй 21-р зуун” цогцолбор сургуулийн  
Дэмжлэгийн багийн хурлын тэмдэглэл-1

Огноо: 2019.09.10 (Мягмар гараг)

Шийдвэрлэсэн асуудлууд:

1. Анги удирдсан багш нараас авсан судалгааг багш Б.Энхжаргал танилцуулав. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлаар орж хөгжлийн бэрхшээлтэй болох нь тогтоогдсон 11 хүүхдээс халамжийн тэтгэмжид хамрагддаг 7 хүүхэд, онош тогтоолгох шаардлагатай 4 хүүхэд байна. Сурахуйн бэрхшээлтэй 30 хүүхэд байгаагаас 29 нь Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөтэй суралцах хүсэлт гаргажээ.
2. Шинээр ирсэн болон хүсэлт гаргасан нийт 29 сурагчийн бодит байдлын судалгаагаар нэг бүрчлэн танилцаж ярилцаад, ГСТ-тэй суралцах хүүхдүүдийг сонгож, дэмжлэгийн чиглэл, хариуцан хөгжүүлэх багш нараа тогтов.
3. 1-р ангийнхны хувьд 1 сар ажиглахаар тогтов.
4. Сурахуйн бэрхшээлтэй нь эргэлзээтэй боловч анги удирдсан багшийн судалгаанд багтсан 3 хүүхдийг дахин судлахаар болов.
5. Сонсголын бэрхшээлтэй 9 настай Д., тархины саажилттай 7 настай Э. нар шилжинэ гээд ирэхгүй, эцэг эхийн утас холбогдохгүй, өнгөрсөн жил байсан хаягаасаа нүүсэн тул харьяа сум/баг, сургуулиас нь албан тодруулга хийхээр болов.
6. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө 1-ээр 8 хүүхэд, ГСТ2-оор 12 хүүхдийг дэмжин хөгжүүлэхээр шийдвэрлэв. Үүнээс:

- Тусгай хэрэгцээт боловсролын төвөөр 10 хүүхэд хичээллэнэ, үүнээс 4 нь тогтмол, 6 нь хичээлийн бус цагаар. 10 хүүхдийг анги удирдсан багш нь ГСТ-өөр дэмжиж хөгжүүлнэ.
  - 11 хүүхдийг анги удирдсан багш нар нь эцэг эхтэй хамтран ажиллаж, дэмжин хөгжүүлнэ.
  - 3 хүүхдийг нийгмийн ажилтан хүүхдийн оролцооны байгууллагаар дамжуулан нийгэмшүүлэн хөгжүүлнэ.
  - Зураг 5, эмчилгээний биеийн тамир 5, дуу хөгжмөөр 3-4 хүүхдийг дэмжлэгээр хангаж, уралдаан тэмцээнд оролцуулна.
  - Сургуулийн эмч 3 хүүхэдтэй ажиллана.
  - Дохионы хэлээр 1 хүүхэд хичээллэнэ.
7. ГСТ-г анги удирдсан багш, тусгай хэрэгцээт боловсролын төвийн багштай хамтран ирэх 7 хоногт багтаан боловсруулж, 2019.09.19-09.20-нд сургалтын менежерээр батлуулна.
- ГСТ-тэй хичээллэж буй хүүхдийн байдал, үр дүн, өөрчлөлт, ахицын талаар 2 дугаар улирлын эхэнд хэлэлцэнэ.

Дээр ашиглагдсан зарим нэр томъёог тайлбарлах хэрэгтэй.

**Урт хугацааны зорилт** гэж тухайн хүүхдийн бодит байдлын судалгааг хийсэн багш нь жилийн эцэст хүрсэн байх зорилго тодорхойлохыг хэлнэ.

2. Урт хугацааны зорилт (Хичээлийн жил 2017/2018 )  
 Сурацагчийн овог, нэр [ ] Анги, бүлэг [ ]-д бүртгэлтэй Хүйс: эр Терсөн огноо [ ] (Нас)

Хөгжлийн ай	Урт хугацааны зорилт	Дэмжлэгийн орчин		
		Хичээлийн бус цагийн үйл ажиллагааны дэмжлэг	Засан сайжруулах үйл ажиллагааны дэмжлэг	Судлагдахууны хүрээнд үзүүлэх дэмжлэг
Өөртөө үйчлэх энгийн чалвар	Гутлаа үдэх, хувцсаа өөрөө тайлах, өмсөх, эвхэж хураах Гар нүүр, шүдээ гүйцэд угааж сурах Алга халбагаа угааж хураадаг болох	ХСТ-д өдөр бүр 09.00-13.00 цагт хичээллэх	Ахуй засал	Нийгэм ахуйн баримжаа
Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	Дохионы хэлд сураах Тоо болон үсгүүдээ бичлэг, дохиогоор хэлдэг болох	Дохионы багш Ц.Ганбаатар ТХБ-ын багш Б.Энхжаргал		Цагаан толгой, тоо тоолол
Нийгэмшихүй	-Өөрийнхөө юу хүсч байгаагаа дохиогоор зөв илэрхийлэх -ангийнхаа биеийн тамрын хичээлд орж, үе тэнгийнхэнтэйгээ харьцаж сурах	Дохионы багш Ц.Ганбаатар	Эмчилгээний биеийн тамир	Дохионы хэл Биеийн тамир
Бие бялдар, хөдөлгөөн	Гарын сарвууг хөгжүүлэх дасгал хийх	-БТ багш С.Отгонгегс 8 тоот дасгал заах, бие дааж хийж хэвшүүлэх -Зургийн багш Ц.Баянжаргал Зураасын дагуу холбож зурах, будах, хайчлах, наахад сургах		Зураг урлал

\*Зөвхөн шаардлагатай гэж үзсэн хөгжлийн айн зорилтыг дэвшүүлнэ.

Тэмдэглэл хөтөлсөн анги удирдсан багшийн нэр, гарын үсэг ...../Б.Энхжаргал /

огноо: 2018-09-10

**Богино хугацааны зорилт** гэж сургуулийн Дэмжлэгийн багаас тодорхойлсон улирлын зорилт юм. Дэмжлэгийн баг нь улирал бүрийн эхэнд товлогдсон хурлаараа өнгөрсөн улирлын богино хугацааны зорилтын биелэлтийг хэлэлцэн, гарсан ахицыг үнэлж хэлэлцэнэ.Тэрчлэн дараагийн улирлын Богино хугацааны зорилтыг хөгжлийн 4 айгаар тодорхойлж, хариуцан ажилладаг багш нарт арга зүй, тохирох хэрэглэгдэхүүний холбогдолтой өөрчлөх, сайжруулах зөвлөмжийг өгдөг.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТУРШЛАГАД СУУРИЛСАН ГАРЫН АВЛАГА

3. Богино хугацааны зорилт

Сурагшачийн овог, нэр: [Хүснэгт] Анги, бүлэг: [Хүснэгт]-д бүртгэлтэй Хүйс: эр Төрсөн огноо: [Хүснэгт] (Г/нас)

Урт хугацааны зорилт Дохионы хэлд суралцах

Тоо болон үсгүүдээ бичдэг, дохиогоор хэлдэг болох Өөртөө үйлчлэх

Дэмжлэгийн орчин /хэзээ, хаана/	Улирал	Богино хугацааны зорилт	Сурагчийн хийх үйл ажиллагаа	Багийн дэмжлэг, арга зүй	Элэг, эхийн дэмжлэг, туслашаа	Улиралын үнэмлээ		
						Сурагчийн үнэмлээ	Багийн үнэмлээ	Үнэмлээ өгсөн хүний нэр
Хөгжүүлэн сургах төвд өдөр бүр	1-р улирал	Дохионы хуруун үсгүүдээ 5-ыг, ойр зуурын үгсийн зангаатай сурах	Багийн дуурайж сурснаа тогтоох	Видео бичлэг үзүүлэх, дагуулан үлгэрлэх арга	Гэрт нь байнга давтуулж, хамтдаа сурах	Хичээлдээ дуртай биш байгаа	Сурснаа мартаж байдаг	Ц.Ганбаатар
	2-р улирал	Дохионы хуруун үсгүүдээ 5-ыг, ойр зуурын үгсийн зангаатай сурах	Багш нараа даган дуурайх, зурагт карт ашиглах	Зурагт карт бэлтгэн ашиглах	Төвшөөхгүй байнга давтуулж, хамтдаа сурах		Ойр зуурын 8 үг дохио зангаагаар сурсан	Б.Энхжаргал
	3-р улирал	Дохионы хуруун үсгүүдээ 5-ыг, ойр зуурын үгсийн зангаатай сурах	Багш нараа даган дуурайх, зурагт карт, дохионы ном ашиглах	Тоглонгоо хичээллэх, дохионы зурагт ном, карт ашиглах	Өөрсдөө дохио зангаа, хуруун үсгээ сурах		Тоглоом болон өдөр тутам хэрэглэдэг үгсээ шинээр 6 сурсан	Ц.Ганбаатар
	4-р улирал	Дохионы хуруун үсгүүдээ 5-ыг, ойр зуурын үгсийн зангаатай сурах	Багш нараа даган дуурайх, зурагт карт, дохионы ном ашиглах	Тоглонгоо хичээллэх	Хичээлд нь тасралтгүй авуулах		Хүүхдээ хөдөө гаргаад, авчраагүй тул үнэмлэх боломжгүй	Сургалтын менежер Ц.Банзрагч
Хөгжүүлэн сургах төвд өдөр бүр	1-р улирал	Гар вүүр, шүдээ гүйцэд угааж сурах	Багийн зааврыг дагах	Видео бичлэг үзүүлэх, дагуулан үлгэрлэх арга	Гэрт нь байнга давтуулж, хамтдаа үйлдэх	Дуртай хийлэг	Дарааллын дагуу зөв угааж сурсан	Эмч А.Түмэнжаргал
	2-р улирал	Гутлаа үлж сурах, ангилаа ирэнгүүт хувцсаа өөрөө тайлах, хураах, өмсөх	Багийн зааврыг дагах	Үлгэрлэн дагуулах, урамшуулах	Гэрт нь байнга итгэл хүлээлгэж, удаарлаж цохихгүй байх	Маш дуртай, гэхдээ удаан	Өөрөө хувцсаа тайлж, зөвхөж ууганцаа хийлэг болсон байв	Нийгмийн ажилтан З.Ариунтөгс
	3-р улирал	Аяга халбагаа угаах, хураах	Багштай зэрэгцэж зогсоод, даган дуурайх, улмаар хэвших	Үлгэрлэн дагуулах, урамшуулах Зурган карт ашиглах	Хүүхдийнхээ өмнүүр орохгүй бие даахад нь туслах	Өглөө орж ирэнгүүт ширээ саялдуудыг тэгшигчдэг болсон	Үдийн пай орж ирмэгц, гараа угааж, аягаа бэлтгэдэг. Дуусаад аяга халбагаа угааж хатааж хэвшсэн	Б.Энхжаргал
	4-р улирал	Цахилгаан товч болон бөөрөнхий товчийг тайлах, тагах	Өөрийн хувцасны цахилгаан, Формны товчийг тайлах, товчлох	Биет үзүүлэн, том якиж товчнууд				Хүүхдээ хөдөө гаргаад, авчраагүй тул үнэмлэх боломжгүй

\* Зөвхөн урт хугацааны зорилтын дэмжлэгийн орчин хэсэгт тусгагдсан тохиолдолд ашиглана

Сурагчийн овог, нэр ..... Анги, бүлэг ..... Хүйс ..... Төрсөн огноо (нас) .....

№	Урт хугааны зорилт	Дүгнэлт	
		Ололт, амжилт	Сайжруулах чиглэл, зөвлөмж
	Гутлаа үдэх, хувьсаа өөрөө тайлах, өмсөх, эхэхж хураах Гар нүүр, шүдээ гүйвд угааж сурах Аяга халбагаа угааж хураадаг болох	Маш дуртайгаар өөртөө үйлчлэхийг оролддог. Улаан боловч гутал хувьсаа өөрөө зөвхөн тайлцаг, хураадаг болсон. Ангидла орж ирэнгүүт өөрөө санаачлагаараа ангийн ширээ санлуудыг тэгшилж, заавал жаахан ч болов хөдөлгөж оролддог. Тоглож дуусаад бүх тоглоомыг яг байр байранд нь хураадаг болсон. Үдийн пай орж ирмэгц, гараа угааж, аягаа бэлтгэлэг. Дуусаад аяга халбагаа угааж хатааж хэвшсэн.	Өөрт нь итгэл хүдээлгэж байгаага мэдэгдэж, урамшуулахад дургтай байдаг. Гэр бүлийн найрсаг харилцаа, тогтоож хандах хандлагыг сайжруулах, хичээлийн хэрэгсэл, дүгнэлтэй болгох.
	Дохионы хэлд сураах Тоо болон үсгүүдээ бичдэг, дохиогоор хэлдэг болох	Цагаан толгойн эхний 5 үсгийг хуруугаар хэлдэг. Мэндчилгээний, талархлын, юмыг хүсэх зэрэг агуулгатай 14 үг зангаагаар хэлж сурсан. 1-3 шифрийг шууд хэлж, 4-5 шифр дээр эргэлзэж хольж сольдог. Дарж бичих эх дээр болон цэгээр холбох зураасуудыг зурдаг. Жижиг самбар дээр дугуй дүрсийг зурахыг эрмэлзэж А үсгийг бичих дургтай.	Гэр бүлийн гишүүд болон ажиллаж буй багш нар уйгагүй дахин дахин яаралгүй зааж, маш тэвчээртэй байх, хэрэглэгдэхүүнээ баяжуулах
	Өөрийнхөө юу хүсч байгаагаа дохиогоор зөв илэрхийлэх -ангийнхаа биеийн тамирын хичээлд орж, үе тэнгийнхэнтэйгээ харьцаж сурах	Бүх харилцааны үел өөрийн дохио зангаага өөрчлөх хандлага ажиглагдсан. Дохио зангаага сурах хандлагатай ч мартдаг. Ангийнхаа биеийн тамирын хичээлд шөөн удаа орсон.	Хамт олонтой байх үедээ санах болох болохгүй араншин, үйлдлийг ойлгуулах. Гэр бүлийн гишүүд болон ажиллаж буй багш нар уйгагүй дахин дахин яаралгүй зааж, маш тэвчээртэй байх, хэрэглэгдэхүүнээ баяжуулах
	Гарын сарвууг хөгжүүлэх дасгал хийх	-БТ багш 7 хоногт 1 удаа хичээллэж 8 тоот дасгал заасан, багшийг даган хийлэг. -Зургийн багш Ц.Баянжаргал 7 хоногт 1 удаа хичээллэж Зураасын дагуу холбож зурах болон Хүрээний дагуу, будахад сурсан.	Хичээлийн хэрэгсэл бэлтгүүлэх, нимбай байхад анхаарах

Тэмдэглэл хөтөлсөн анги удирдсан багшийн  
нэр, гарын үсэг ..... Б.Энхжаргал, Ц.Г.анбаатар  
Танилцсан, эцэг (эх, асран хамгаалагч)-ийн  
нэр, гарын үсэг ...../Д.Энхтүвшинг/

огноо: 2019-05-10

огноо: □□□□ □□

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж хэвшсэнээр дараах үр дүн гарч байгааг Дэмжлэгийн багийн гишүүд онцолж байна. Үүнд:

- Багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах аргазүйтэй болсон.
- Хамтын ажиллагаа сайжирсан. Хүүхэд бүрийн онцлогийг харгалзан, сургуулийн удирдлага, багш, ажилчид, эцэг эхийн оролцоотой тодорхойлсон зорилтын хүрээнд ойлголтоо нэгтгэн ажиллаж чаддаг.
- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө болон Ээлжит хичээлийн хөтөлбөрийг хамтран боловсруулах нь багш ажлын байран дээрээ мэргэжил боловсролоо дээшлүүлэх хэлбэр болохын зэрэгцээ сургалтын чанар сайжрахад эергээр нөлөөлж байна.
- Сурагчийн хувьд сурах сонирхол нэмэгдэж, өөртөө илүү итгэлтэй болсон.

## ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас  
сургуульд илгээх мэдээллийн хуудас

Тэмдэглэсэн огноо	..... оны .... сар .... өдөр	
Тэмдэглэсэн хүний нэр		
Хүүхдийн овог нэр		
Нас		
Хүйс	<input type="checkbox"/> Эр	<input type="checkbox"/> Эм
Зан үйл, суралцахуйн онцлог		
Сургуулийн зүгээс анхаарах зүйлс		

Доорх хэсэгт цэцэрлэг, хүүхэд хөгжүүлэх төв дээр хэрэгжүүлж буй  
үйл ажиллагааны талаар товч бөглөнө. Зөвхөн боломжтой хэсгийг  
бөглөнө үү.



Ай	Цэцэрлэг хамрагдаж эхлэх үеийн байдал	Цэцэрлэг, төв дээрх дэмжлэгийн агуулга	Одоогийн байдал
Сонсох			
Ярих			
Харах			
Том булчингийн хөдөлгөөн			
Жижиг булчингийн хөдөлгөөн			
Үсэг, тоо сонирхох байдал			
Зураг зурах, урлах			
Юмс, үзэгдлийг сонирхох байдал			
Нийгэмшихүй			
Үйлдэл			
Бие даах чадвар			

Боловсруулсан: (.....)

Хянасан: (.....)

Хавсралт 2. Сургуульд хамрагдалтыг дэмжих  
хурлын шийдвэрийн хуудас

<b>Тэмдэглэсэн огноо</b>	<b>..... оны .... сар .... өдөр</b>
Тэмдэглэл хөтөлсөн хүний нэр	
Хүүхдийн овог нэр	
Нас	
Хүйс	<input type="checkbox"/> Эр <input type="checkbox"/> Эм
Хуралд оролцогчийн нэр	

<b>Цэцэрлэгт явж байсан эсэх, одоо хамрагдаж буй цэцэрлэг</b>		<b>Элсэхийг хүсэж буй сургууль</b>
Онош (Оношлогдсон огноо, оношилсон ЭМБ-ын нэр)		.... оны ... сар ... өдөр (..... .....)
Хүүхдийн хүсэл		
Эцэг эхийн хүсэл		
Хурлаар ажиглагдсан онцлог байдал		
	Ай	Шаардлагатай орчин нөхцөл
Сургуульд хамрагдах, сургуульд явахад шаардлагатай орчин нөхцөл (Сургууль)	Сургуульдаа ирж, очих боломж Ахуй амьдрал Суралцах чадвар Бусад	

– Шийдвэрлэсэн асуудал

---

Сургууль, бүлэг

Давтамж

Хугацаа

---

– Сургуульд элсэхэд шаардлагатай бэлтгэл ажлууд

<b>Зорилт</b>	<b>Авах арга хэмжээ</b>	<b>Хариуцах хүн, байгууллага</b>
---------------	-------------------------	--------------------------------------

Асран хамгаалагчийн овог нэр  
Гарын үсэг

(.....)

Зөвлөлийн даргын овог нэр  
Гарын үсэг

(.....)

---

Журмыг боловсруулсан:  
БСУГ-ын мэргэжилтэн: Д.Баасансүрэн

### Хавсралт 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад салбаруудын оролцоо

#### **Дөрөв. Холбогдох байгууллагуудын эрх, үүрэг**

##### 4.1. Боловсрол, соёл, урлагийн газрын эрх, үүрэг

1. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхэд тэдний байршилд тохирсон оновчтой бодлого төлөвлөлт хийх;
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боломж, хэрэгцээнд тохирсон ялгаатай хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах
3. Багш нарыг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр сургалт мэдээллээр хангах, арга зүй ур чадварыг нэмэгдүүлэх үйл ажиллагаануудыг зохион байгуулах
4. Сургууль, цэцэрлэгийн сургалтын тохируулгат орчин бүрдүүлсэн байдалд хяналт хийх
5. Тэдгээр хүүхдүүдтэй ажиллаж байгаа багш нарын нэмэгдэл цалин хөлс, шагнал урамшлын асуудлыг шийдвэрлэх.

##### 4.2. Сумын засаг даргын эрх, үүрэг

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн байршил судалгаа мэдээллийг нарийвчлан гарган, хуульд заасан үүргээ биелүүлж, боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулж суурь боловсролыг заавал эзэмшүүлэх асуудлыг шийдвэрлэх
2. Хүүхдээ сургуульд хамруулах хүсэлгүй эцэг эх, асран хамгаалагчдын хандлагыг өөрчлөх, хүүхдийн аж байдлын судалгааг хийж, холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх

3. Тухайн сумын Засаг дарга, ЗДТГ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах ээлтэй дэд бүтцийн орчныг бий болгох
4. Хүүхдийн сурч боловсрох, хөгжих эрхийг хангах чиглэлээр цэцэрлэг, сургууль боловсролын бусад байгууллагуудтай хамтран ажиллах, хяналт тавих
5. Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлаар орж, боловсролын үйлчилгээнд хамрагдах шийдвэр авсан хүүхдүүдийн талаар Сургуулийн дэмжлэгийн багийг хуралдуулж, суралцах анги, багш, сургуулийн орчинд тохируулга хийх асуудлыг хэлэлцэж, шийдвэрийг 6-р сарын 15-ны дотор Боловсрол, соёл, урлагийн газарт ирүүлэх.

#### 4.3. Сургууль, цэцэрлэгийн захирал эрхлэгчийн эрх, үүрэг

1. Суралцахаар ирж байгаа хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр нь үл ялгаварлан заавал хүлээж авч суралцуулах
2. Шинээр элссэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн ангид мэдээллийн системд бүртгэж авна
3. Тухайн хүүхэдтэй ажиллаж байгаа багшид цалингийн урамшууллыг хэрхэн олгох асуудлыг шийдвэрлэж төсөвт тусгуулна
4. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх асуудлыг төсөвт тусгуулж, шийдвэрлүүлэх
5. Сургууль, цэцэрлэгийн дэмжлэгийн багийг байгуулан, тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан тохируулгат орчин, ганцаарчилсан сургалтын хөтөлбөр, багшийн арга зүй,

эцэг эхийн дэмжлэг зэргийг хэлэлцэж шийдвэрлэдэг тогтолцоо бүрдүүлэх

6. Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн залгамж холбоог хангаж цэцэрлэгт тухайн хүүхэдтэй ажиллаж байсан багш, сургуулийн хариуцах багшид хүлээлгэж өгөх хүүхдийн онцлог, ажиллах арга барилын талаар мэдээлэл солилцох
  7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх эерэг ойлголт хандлагыг төлөвшүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг иргэд олон нийт, багш ажилчид, сурагчдын дунд зохион байгуулах, удирдлагаар хангах
  8. Хамран сургах тойргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх мэдээ, судалгааг багын засаг даргатай хамтран гаргах боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулахад онцгой анхаарч ажиллах
  9. Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлаар орж боловсролын үйлчилгээнд хамрагдах шийдвэр авсан хүүхдүүдийн талаар сургуулийн дэмжлэгийн багийг хуралдуулж суралцах анги, багш, сургуулийн орчинд тохируулга хийх асуудлыг хэлэлцэж шийдвэрийг 6-р сарын 15-ны дотор БСУГ-т ирүүлэх.
- 4.4. Хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын эрх, үүрэг
1. Хурлаар орж боловсрол эзэмшүүлэх шийдвэр өгсөн хүүхдүүдийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
  2. Шийдвэрлэхэд хүндрэлтэй хүүхдийн кейс хэлэлцүүлгийг зохион байгуулах асуудлаар сургууль хамрагдалтыг дэмжих зөвлөлд санал оруулах, зохион байгуулах

3. Хүүхдийг эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх
4. Цэцэрлэг сургуульд хамрагдахгүй байгаа байнгын асаргаа тогтоолгосон хүүхдийн холбогдох сургуульд нь илгээх холбон зуучлах
- 4.5. Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын эрх, үүрэг
  1. Хүүхдийн эрхийн тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуулийг эцэг эхэд сурталчлан, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх
  2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх
  3. Насан туршийн болон өдөр өнжүүлэх төвд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын чанар үйл ажиллагаанд үнэлгээ хийх
  4. Эрсдэлт нөхцөл болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд мэргэжлийн байгууллага болон хамтарсан багийн оролцоотой хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх
- 4.6. Эцэг эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг
  1. Хүүхдэд гэр бүлдээ аз жаргалтай, хайр халамжтай, бүхий л талаар хөгжих орчныг бүрдүүлэх
  2. Хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах
  3. Хүүхдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмших,

авьяас чадварыг нь хөгжүүлэхэд сургууль, хүүхдийн болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдтэй хамтран ажиллах

4. Төрөөс авч байгаа мөнгөн тэтгэмжийг хүүхдийн эрүүл мэнд хөгжил, төлөвшилд нь зориулах
5. Харьяаллын дагуу сургууль, цэцэрлэгт хамруулах хүсэлтийг холбогдох байгууллагуудад болон зөвлөлд гаргах
6. Хүүхдээ сургууль, цэцэрлэгт хамрагдах ёстой насанд нь бүртгүүлэх, сургах
7. Шийдвэрийг зөрчиж хүүхдийн сургуулийг тасалдуулсан, завсардуулсан тохиолдолд нийгмийн халамжийн үйлчилгээг цуцлах буюу бусад хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

#### 4.7. Төрийн бус байгууллагын эрх, үүрэг

1. Хурлаас гарсан шийдвэрийн дагуу хөгжүүлэх төвдөө хүүхдийг хүлээн авах сургах
2. Төвөөс ердийн сургуульд шилжүүлэх шаардлагатай хүүхдүүдийн асуудлыг оруулж хэлэлцүүлэх, сургуульд нь илгээх шийдвэр гаргуулах
3. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаатай хамтран хүүхдийн аж байдлыг сайжруулах арга хэмжээг авч ажиллах
4. Ахуй амьдралын дэмжлэг зайлшгүй шаардлагатай хүүхдэд тусламж дэмжлэг үзүүлэх
5. Зөвлөлөөс гарсан шийдвэрийн дагуу хамтран хэрэгжүүлэх ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх.





Хавтсанд Урлагийн зөвлөлөөс  
хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд зохион байгуулсан  
“Бид чадна” арга хэмжээний үеэр хийгдсэн  
бүтээлүүдийн зургийг оруулав.

ISBN 978-9919-9678-6-4



9 789919 242909